*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 7481 дүгээрт бүртгэв.*

## СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар А/365 | Улаанбаатар хот |

## ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг, Стандарт, хэмжил зүйн газрын Даргын зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журмыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор Хууль зүйн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлэхийг Хэмжил зүйн бодлогын газрын дарга (Д.Бэхбат)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (Б.Санчирдорж)-т даалгасугай.

5.Журмыг мөрдөж эхэлсэн өдрөөс Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны А/137 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА С.БАТБААТАР

Бүртгэлийн дугаар 03
ХУУЛБАР ҮНЭН
Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Архивын эрхлэгч С. Дуурээ
2026 оны 01 сарын 14-ний өдөр

*Стандарт, хэмжил зүйн газрын даргын*
*2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн*
*А/365 дугаар тушаалын хавсралт*

# ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ЗАГВАРЫГ ТУРШИХ, БАТЛАХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Хэмжил зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу хэмжих хэрэгслийн загварыг турших, үр дүнг хүлээн зөвшөөрөх, батлах хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэж хэмжлийн нэгдмэл байдлыг хангахад оршино.

1.2.Энэ журмаар хэмжих хэрэгслийн загварыг турших, үр дүнг хүлээн зөвшөөрөх, батлах, бүртгэх үйл ажиллагаа, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Хэмжил зүйн төв байгууллага” гэх), хэмжил зүйн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Хэмжих хэрэгслийн загварын туршилтыг хэмжил зүйн төв байгууллага, хэмжил зүйн мэргэжлийн байгууллага (цаашид “эрх бүхий байгууллага” гэх) холбогдох хууль тогтоомж, стандарт болон энэ журмын дагуу гүйцэтгэнэ.

1.4.Хэмжих хэрэгслийн загварыг турших, үр дүнг хүлээн зөвшөөрөх, батлах, сунгах, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг хүсэлт ирүүлснээс хойш ажлын 30 хоногт багтаан эрх бүхий байгууллага зохион байгуулна.

1.5.Энэ журамд заасан нэр томьёог Хэмжил зүйн тухай хууль болон олон улсын байгууллагаас баталсан нэр томьёоны тодорхойлолтын стандартад заасны дагуу ойлгож хэрэглэнэ.

1.6.Хэмжих хэрэгслийн загварын туршилтыг гүйцэтгэсэн ажлын хэсгийн дүгнэлт нь тухайн хэмжих хэрэгслийн загварын шинж чанар, бүтэц, ажиллах зарчим, хэмжил зүйн болон техникийн үзүүлэлтийг тодорхойлсон байна.

## Хоёр. Хэмжих хэрэгслийн загварын туршилтын ажлын зохион байгуулалт

2.1.Хэмжих хэрэгслийн загварыг турших, үр дүнг хүлээн зөвшөөрөх, батлах, сунгах, хэмжих хэрэгслийг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг хэмжил зүйн төв байгууллага зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

2.2.Хэмжих хэрэгслийн загварын туршилтын хүсэлт гаргах.

2.2.1.Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх чадавхаа үнэлүүлсэн, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн аж ахуйн нэгж болон хэмжил зүйн мэргэжлийн байгууллага нь (цаашид “хүсэлт

гаргагч” гэх) хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох зорилгоор тухайн хэмжих хэрэгслийн загварыг туршилтад хамруулах[1], үр дүнг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлтээ маягтын дагуу гаргаж, дараах шаардлага хангасан баримт бичиг, материалыг монгол хэл дээр бүрдүүлэн эрх бүхий байгууллагад цахимаар ирүүлэх ба хэмжих хэрэгслийн 3 (гурав) хүртэлх биет загварыг бүртгүүлэн өгнө. Үүнд:

2.2.1.1.хэмжих хэрэгслийг загварын туршилтад хамруулах тухай албан бичиг;

2.2.1.2.хэмжих хэрэгслийн бүтэц, хэмжил зүйн ба техникийн үзүүлэлт, ажиллах зарчим, холболтын бүдүүвч зураг, технологийн заавар зэргийг багтаасан техникийн баримт бичиг;

2.2.1.3.хэмжих хэрэгсэлд хийх техник үйлчилгээ, суурилуулалт, угсралт, засвар тохируулгын талаарх мэдээлэл, гарын авлага, заавар;

2.2.1.4.хэмжих хэрэгслийн ашиглалт, хадгалалтын талаарх хэрэглэгчид зориулсан гарын авлага.

2.2.1.5.хууль эрхийн хэмжил зүйн олон улс байгууллагын болон үйлдвэрлэгч орны үндэсний хэмжил зүйн байгууллагын эсхүл эрх бүхий байгууллагын загварын баталгааны хүчин төгөлдөр гэрчилгээ, түүний баталгаат хуулбар, загварын туршилтын үр дүн, протокол тайлан;

2.2.1.6.хэмжих хэрэгслийн программ хангамж, мэдээлэл дамжуулах протокол, тайлангийн электрон хэлбэр;

2.2.1.7.тухайн загварын хэмжих хэрэгслийн өнгөт фото зураг;

2.2.1.8.үйлдвэрлэгч, нийлүүлэгч байгууллагын танилцуулга.

2.3.Эрх бүхий байгууллага хүсэлт гаргагчаас ирүүлсэн баримт бичиг, материал болон хэмжих хэрэгслийн биет загварыг судлан тэдгээрт үзлэг хийх ба бүрдэл дутуу, шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.

2.4.Хүсэлт гаргагч нь хэмжих хэрэгслийн загварыг турших, үр дүнг хүлээн зөвшөөрөх, сунгах, батлахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баталсан төлбөрийн хэмжээ, загварын туршилтын ажлын төсөвт хөтөлбөрт заасны дагуу бүрэн хариуцна.

2.5.Загварын туршилт гүйцэтгэсэн ажилтанд олгох ажлын хөлсийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баталсан төлбөрийн хэмжээний дагуу тооцож, загварын туршилт гүйцэтгэсэн эрх бүхий байгууллагын даргын тушаалаар олгоно.

Тайлбар: ус, хий, цахилгааны тоолуурын загвар батлагдсан тохиолдолд 1 (нэг) ширхэг хэмжих хэрэгслийг холбогдох хэмжлийн

[1] Хэрэглээний хэмжих хэрэгсэлд 3 ширхэг биет загвар заавал ирүүлсэн байна.

лабораторид тухайн загварын баталгааны хугацаа дуусах хүртэл хадгалуулна.

## Гурав. Хэмжих хэрэгслийн загварын туршилтын үйл ажиллагаа

3.1.Хүсэлт гаргагчийн ирүүлсэн баримт бичиг, холбогдох материал, биет загвар шаардлага хангасан тохиолдолд хэмжих хэрэгсэлд загварын туршилт хийх үүрэг бүхий ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх)-ийг хэмжил зүйн төв байгууллагын хэмжил зүйн асуудал хариуцсан нэгжийн дарга, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан удирдамжаар томилно.

3.2.Хэмжих хэрэгслийн загварын туршилтыг тухайн хэмжлийн төрлөөр олон улс болон Хэмжил зүйн төв байгууллагын сургалт хамрагдаж, мэргэшсэн 3 (гурав) буюу түүнээс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хийж гүйцэтгэнэ.

3.3.Ажлын хэсэг хүсэлт гаргагчийн энэ журмын 2.2.1-д заасан баримт бичиг, холбогдох материал, биет загвартай танилцаж, холбогдох стандартын шаардлага хангасан эсэхэд нарийвчилсан үзлэг хийж, нэмэлт материал шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргагч аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэж, бүрдүүлбэрийг хангуулж авах бөгөөд шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.

3.4.Ажлын хэсэг загварын туршилтын ажлын төсөвт хөтөлбөр боловсруулж, хэмжил зүйн төв байгууллагын хэмжил зүйн асуудал хариуцсан нэгжийн дарга, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар батлуулна.

3.5.Хүсэлт гаргагч гэрээний нөхцөл, загварын туршилтын ажлын төсөвт хөтөлбөртэй танилцаж гарын үсэг зурж баталгаажуулснаар загварын туршилтыг эхлүүлнэ.

3.6.Загварын туршилт хийх үүрэг бүхий ажлын хэсэг хэмжих хэрэгслийн загварын туршилтыг холбогдох хууль тогтоомж, стандарт, батлагдсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэхээс гадна загварын туршилтын үнэлгээний хуудас (энэ журмын 1 дүгээр хавсралт)-ыг бөглөж, тухайн хэмжих хэрэгслийн хэмжил зүйн болон техникийн үзүүлэлтэд нийцүүлэн туршилт хийх арга аргачлалыг тодорхойлж, цаг уур болон ашиглалтын нөхцөлд тохирч байгаа эсэхийг шалгаж туршина.

3.7.Хэмжил зүйн төв байгууллага хэмжих хэрэгслийн загварын туршилтыг явуулахад техникийн болон хүний нөөцийн хувьд боломжгүй тохиолдолд хэмжил зүйн мэргэжлийн байгууллага, судалгааны хүрээлэн эсхүл их, дээд сургуулийн лаборатори, үйлдвэрлэгчийн эталон тоног төхөөрөмжийг ашиглаж, мэргэжлийн ажилтныг оролцуулж болно. Тухайн байгууллагад ашиглаж байгаа эталон тоног төхөөрөмж нь шалгалт тохируулгад хамрагдаж, нэгж дамжуулалт хангагдсан байна.

## Дөрөв. Загварын туршилтын үр дүнг хүлээн зөвшөөрөх

4.1.Импортлох хэмжих хэрэгсэлд дараах эрх бүхий байгууллагаас загварыг баталж, үр дүнг хавсаргасан гэрчилгээ олгосон тохиолдолд загварын туршилтыг давтан хийхгүйгээр загварын туршилт, баталгааны үр дүнг хүлээн зөвшөөрч болно. Үүнд

4.1.1.Хууль эрхийн хэмжил зүйн олон улсын байгууллага (OIML CS);

4.1.2.Хууль эрхийн хэмжил зүйн олон улсын байгууллага (OIML CS)-аас эрх авсан хэмжил зүйн байгууллага, үйлдвэрлэгч;

4.1.3.Хэмжил зүйн төв байгууллагатай загварын туршилтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх талаар гэрээ, хэлэлцээр байгуулсан гадаад орны хэмжил зүйн төв байгууллага.

4.2.Энэ журмын 2.2.1 болон 4.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд эрх бүхий байгууллагаас томилогдсон ажлын хэсэг санал, дүгнэлт гаргаж, хэмжил зүйн төв байгууллагад ирүүлнэ.

## Тав. Загварын баталгааны хугацааг сунгах

5.1.Тухайн хэмжих хэрэгслийг хэрэглэгч байгууллага болон сонирхогч тал загварын баталгааны хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулах хүсэлтээ маягтын дагуу гаргаж, дараах шаардлага хангасан баримт бичиг, материалыг монгол хэл дээр бүрдүүлэн эрх бүхий байгууллагад цахимаар ирүүлэх ба хэмжих хэрэгслийн 3 (гурав) хүртэлх биет загварыг бүртгүүлэн өгнө. Үүнд:

5.1.1.хэмжих хэрэгслийн загварын баталгааны гэрчилгээний хугацааг сунгуулах тухай албан бичиг;

5.1.2.хэмжих хэрэгслийн бүтэц, хэмжил зүйн болон техникийн үзүүлэлт, ажиллах зарчим, холболтын бүдүүвч зураг, технологийн заавар;

5.1.3.хэмжих хэрэгслийн загварын баталгааны гэрчилгээний хуулбар;

5.1.4.хэмжил зүйн болон хяналтын эрх бүхий байгууллага, хангагч, хэрэглэгчээс тухайн хэмжих хэрэгслийн ашиглалтын талаарх тодорхойлолт, албан бичиг.

5.2.Эрх бүхий байгууллагаас томилогдсон ажлын хэсэг хэмжих хэрэгслийн тухайн загвартай холбоотой энэ журмын 6.1-д заасан нөхцөл, байдал илрээгүй бол удирдамжийн дагуу тайлан, санал, дүгнэлт гаргана.

5.3.Энэ журмын 5.2-д заасан санал, дүгнэлтээр тэнцсэн хэмжих хэрэгслийн загварын баталгааны хугацааг Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар 10 жил хүртэл хугацаатай сунгана.

5.4.Загварын баталгааны гэрчилгээний хугацааг сунгах тайлан, санал, дүгнэлтээр дараах төрлийн хэмжих хэрэгслийн загварыг

баталсан гэрчилгээг хугацаагүй олгож болох ба баталгаажуулалт хийх, төрийн хяналт явуулах замаар хэмжил зүйн хяналт шалгалтад хамруулна. Үүнд:

- автоцистерн;
- автомашины жин, худалдааны болон эмнэлгийн жин; туухай ($M_2$, $M_{2-3}$, $M_3$ анги);
- эмнэлгийн термометр, цусны даралтын аппарат;
- худалдааны метр, сүмбэнметр;
- амьсгал дахь спиртийн агууламж тогтоох хэмжүүр;
- үр тарианы чийг хэмжигч;
- 6 кВ-оос дээш хэмжих хязгаартай гүйдэл, хүчдэлийн трансформатор.

**Зургаа. Хэмжих хэрэгслийн батлагдсан загварт магадлан туршилт хийх**

6.1.Хэмжих хэрэгслийн батлагдсан загварт дараах тохиолдолд магадлан туршилт хийнэ.

6.1.1.үйлдвэрлэсэн буюу импортлосон хэмжих хэрэгслийн чанар байдлын талаар гаргасан санал, гомдол, хэмжил зүйн болон хяналтын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мэдэгдэл, хүсэлт;

6.1.2.хэмжих хэрэгслийн хийц, загвар, үйлдвэрлэлийн технологийн горим болон уг хэмжих хэрэгслийн загвар, хэмжил зүй, техникийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт орсон.

6.2.Загварын магадлан туршилтыг эрх бүхий албан тушаалтны удирдамжаар томилогдсон ажлын хэсэг гүйцэтгэх ба хэсэгчилсэн болон хязгаарлагдмал туршилтыг явуулж, санал, дүгнэлт гаргана.

**Долоо. Хэмжих хэрэгслийн загварыг батлах, бүртгэх**

7.1.Хэмжих хэрэгслийн загварын туршилтыг гүйцэтгэх, загварын туршилтын үр дүнг хүлээн зөвшөөрөх, загварын баталгааны гэрчилгээний хугацааг сунгах, загварыг магадлан туршилт хийсний дараа эрх бүхий албан тушаалтны томилсон ажлын хэсэг туршилтын үр дүн, тайлан, санал, дүгнэлт, шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргана.

7.2.Ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлт, зөвлөмжийг биет загварын хамт хэмжил зүйн төв байгууллагад ирүүлж, хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар хэмжих хэрэгслийн загварыг баталж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэж, загварын баталгааны гэрчилгээ олгоно.

7.3.Хэмжил зүйн төв байгууллага болон хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийг хянаж үзээд хууль, дүрэм, журам, стандартын шаардлага хангаагүй тохиолдолд загварын туршилт гүйцэтгэсэн ажлын хэсэгт

буцаах ба шаардлагатай гэж үзвэл шинээр ажлын хэсгийг байгуулж болно.

7.4.Хэмжил зүйн төв байгууллагаас батлагдсан гэрээний загварын дагуу “Хэмжих хэрэгслийн загварын баталгааны гэрээ”-ний төслийг боловсруулж, хүргүүлэх ба ажлын 5 хоногийн дотор гэрээ байгуулж, баталгаажуулна.

7.5.Загварын туршилттай холбогдон гарсан шийдвэр, загварын баталгааны гэрчилгээ, загварын баталгааны тэмдгийн загвар, батлагдсан гэрээг Хэмжил зүйн төв байгууллагын загварын туршилт хариуцсан мэргэжилтэн ажлын 3 хоногт багтаан хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

7.6.Шинээр олгох загварын баталгааны гэрчилгээний хүчинтэй хугацаа 5 жил байна.

7.7.Ажлын хэсгийн туршилтын үр дүн, тайлан, санал, дүгнэлтээр тухайн хэмжих хэрэгслийн хэмжил зүйн ба техникийн үзүүлэлтүүд нь холбогдох стандарт, техникийн баримт бичигт заасан нөхцөл шаардлагыг хангаагүй, үр дүн нь тэнцээгүй, загварын туршилтын үр дүнг хүлээн зөвшөөрөх боломжгүй тохиолдолд хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

**Найм. Хэмжих хэрэгслийн загварын баталгааны тэмдэг**

8.1.Хэмжих хэрэгслийн загвар нь батлагдаж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн бол хэмжил зүйн төв байгууллагаас загварын баталгааны тэмдгийг хүсэлт гаргагч болон хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй импортлогч байгууллагад хэрэглүүлэх бөгөөд төлбөртэй байна.

8.2.Өмнө нь загвар нь батлагдаж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн хэмжих хэрэгслийг өөр аж ахуйн нэгж байгууллага импортлох тохиолдолд албан хүсэлт гаргаж, хэмжил зүйн байгууллагад бүртгүүлэн загварын батлагааны тэмдгийг хэрэглэнэ.

8.3.Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэгч, импортлогч байгууллага загвар нь батлагдсан, загварын баталгааны гэрчилгээтэй хэмжих хэрэгслийг хэрэглэгчдэд таниулах, нотлох, хуурамчаар үйлдвэрлэхээс сэргийлэх зорилгоор хэмжих хэрэгслийн загварын баталгааны тэмдгийг ашиглана.

8.4.Хэмжих хэрэгслийн загварын баталгааны тэмдгийг үйлдвэрлэгчээс тухайн хэмжих хэрэгсэл тус бүрд тод харагдахуйц, арилахгүй байхаар стандартад нийцүүлэн тэмдэглэсэн байна.

8.5.Хэмжих хэрэгслийн загварын баталгааны тэмдэг нь энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан загвартай дэвсгэр өнгө нь цагаан, хэмжлийн төрлийг илэрхийлэх дугаар нь хар өнгөтэй байх ба “З” үсэг болон загварыг баталсан он байна. Загварын баталгааны

тэмдгийг загварын дагуу стандартад нийцүүлэн томруулах буюу багасган хэрэглэж болох ба хэмжээ нь 1:1-ийн харьцаатай байна.

8.6.Загварын баталгааны тэмдгийг эзэмшигч нь хэмжил зүйн төв байгууллага байх ба хүсэлт гаргагч эсхүл хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй импортлогч байгууллага нь зөвхөн загварын баталгааны хүчинтэй хугацаанд хэрэглэх эрхтэй.

8.7.Хэмжих хэрэгслийн загварын баталгааны хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд загварын баталгааны тэмдэг хэрэглэхийг хориглоно.

## Ес. Хэмжих хэрэгслийн загварыг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх, бүртгэлээс хасах

9.1.Загвар нь батлагдсан хэмжих хэрэгслийг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд энэ журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэнэ.

9.2.Дараах тохиолдолд загварын баталгааг хүчингүй болгож, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангийн бүртгэлээс хасна.

9.2.1.Энэ журмын 5, 6 дугаар зүйлд заасан давтан болон магадлан туршилтаар хэмжих хэрэгслийн хэмжил зүйн болон техникийн үзүүлэлт шаардлага хангахгүй нь тогтоогдсон;

9.2.2.Загварын баталгааны хугацаа дуусгавар болсон.

## Арав. Хариуцлага

10.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ

*Хэмжих хэрэгслийн загварыг турших,
батлах журмын 1 дүгээр хавсралт*

# ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ЗАГВАРЫН ТУРШИЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

| Д/д | Үндсэн шаардлага | Үзүүлэлт |
|---|---|---|
| 1 | Загварын нэр ба тэмдэглэгээ | |
| 2 | Үйлдвэрлэгч | |
| 3 | Зориулалт ба хэрэглээ (ашиглах салбар) | |
| 4 | Үйлдвэрийн дугаар | |
| 5 | Өнгө, хийц | |
| 6 | Хэмжих хязгаар, нарийвчлалын анги, бусад | |
| 7 | Ажиллах орчны нөхцөл | |
| 8 | Хамгийн их зөвшөөрөгдөх алдаа | |
| 9 | Ажиллах зарчим | |
| 10 | Загварын онцлог | |
| 11 | Загварын үндсэн материал | |
| 12 | Шалгах арга аргачлал, стандарт | |
| 13 | Загварын туршилт гүйцэтгэхэд ашиглагдах ажлын эталон тоног төхөөрөмж, нарийвчлалын анги, хэмжлийн эргэлзээ | |
| 14 | Туршилтын лабораторийн орчны нөхцөл | |
| 15 | Хоёрдогч тооцоологч (заагч хэмжүүр) | |
| 16 | Тусгаарлагдсан хэмжигч, дамжуулагч (урсгал эсхүл дууны мэдрэгч гэх мэт) | |
| 17 | Нэмэлт электрон төхөөрөмж | |
| 18 | Мэдээллийн нэмэлт электрон төхөөрөмж, дамжуулагч (тоолуурт хавсаргасан) | |
| 19 | Программ хангамжтай эсэх | |
| 20 | Программ хангамжийн ажиллах зарчим<br>(IT инженерийн санал, дүгнэлтийг шаардлагатай тохиолдолд хавсаргах) | |
| 21 | Тохируулгын код -1 | |
| 22 | Тохируулгын код-2 | |
| 23 | Тохиргоо хийсэн эсэх | |
| 24 | Хэмжих хэрэгслийн үйлдвэрлэгчийн баталгаат хугацаа | |
| 25 | Дүгнэлт: | Тэнцсэн / Тэнцээгүй |
| 26 | Загварын туршилт гүйцэтгэсэн ажлын хэсэг:<br>(Албан тушаал, нэр, гарын үсэг) | ............................<br>............................<br>............................ |
| 27 | Туршилт гүйцэтгэсэн огноо: | |

*Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах журмын
2 дугаар хавсралт*

**ЗАГВАРЫН БАТАЛГААНЫ ТЭМДЭГ**




20 - Загварын баталгааны гэрчилгээ анх олгосон он;
0123 - Загварын баталгааны гэрчилгээний дугаар;
0012 - Хэмжлийн төрлийн код (02- Хүндийн хэмжил, 04-Цахилгаан, соронзон хэмжил гэх мэт).

*Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах журмын*
*3 дугаар хавсралт*

## ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ХЭМЖИЛ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН УЛСЫН НЭГДСЭН САНГИЙН БҮРТГЭЛ

| Д/д | Хэмжих хэрэгслийг загварын туршилтад хамруулсан байгууллага | Үйлдвэрлэгч улс, үйлдвэр, компани | Хэмжих хэрэгслийн нэр, загвар | Хэмжил зүйн үзүүлэлт | Хэмжих хэрэгслийн загварыг баталсан | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шийдвэр | Огноо | Гэрчилгээний дугаар | Бүртгэлийн дугаар | Хүчинтэй хугацаа |
| 1 | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 7482 дугаарт бүртгэв.*

## СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар А/366 | Улаанбаатар хот |

## ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь заалт, Стандарт, хэмжил зүйн газрын Даргын зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаал гарснаас хойш ажлын таван өдрийн дотор Хууль зүйн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлэхийг Хэмжил зүйн бодлогын газрын дарга (Д.Бэхбат)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (Б.Санчирдорж)-т даалгасугай.

5.Журмыг мөрдөж эхэлсэн өдрөөс Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны А/136 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА С.БАТБААТАР


Бүртгэлийн дугаар 04
ХУУЛБАР ҮНЭН
Монгол улсын Засгийн газрын
тохируулагч агентлаг
СТАНДАРТ
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Архивын эрхлэгч
С. Дүүрээ
2026 оны 01 сарын 14-ний өдөр

*Стандарт, хэмжил зүйн газрын даргын*
*2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн*
*А/366 дугаар тушаалын хавсралт*

# ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛД ШАЛГАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Хэмжил зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг хэмжил зүйн төв болон аймаг дахь хэмжил зүйн байгууллага, хэмжил зүйн мэргэжлийн байгууллага (цаашид “хэмжил зүйн байгууллага” гэх) гүйцэтгэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулах бөгөөд шалгалт баталгаажуулалтыг хэмжил зүйн байгууллага гүйцэтгэнэ.

1.3.Шалгалт баталгаажуулалтад хамрагдах хэмжих хэрэгслийн тэмдэглэгээ, шошго нь дараах шаардлагыг хангасан байна.

1.3.1.хэмжих хэрэгслийн үйлдвэрлэгч, загвар, дугаар ба таних тэмдэг, хэмжил зүйн үзүүлэлтүүд;

1.3.2.импортлогч аж ахуйн нэгж, байгууллагын нэр эсвэл таних тэмдэг;

1.3.3.стандартад заасан холбогдох шаардлага;

1.3.4.хэмжих хэрэгслийн загварын баталгааны тэмдэг;

1.3.5.монгол, англи, орос хэлний аль нэг дээр.

1.4.Хэмжих хэрэгслийн загварын туршилтад хамрагдаагүй, загварын гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, загварын баталгааны тэмдэггүй хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулахгүй.

## Хоёр.Шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагаа, зохион байгуулалт

2.1.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг хэмжил зүйн төв байгууллагаас улсын шалгагчийн эрх авсан ажилтан гүйцэтгэнэ.

2.2.Улсын шалгагч нь Хэмжил зүйн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтад заасны дагуу зөвхөн өөрийн харьяалагдах нутаг дэвсгэрт эсвэл холбогдох салбарын хүрээнд ашиглаж байгаа хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалтыг гүйцэтгэнэ.

2.3.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтад ашиглаж байгаа ажлын эталоныг улсын эталоноос эсхүл гадаад орны хүлээн зөвшөөрсөн дээд шатны хэмжлийн эталоноос нэгж дамжуулан шалгалт тохируулгад хамруулсан байна.

2.4.Шалгалт баталгаажуулалтыг холбогдох стандарт, техникийн зохицуулалт, арга аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

2.5.Шалгалт баталгаажуулалтад тэнцсэн хэмжих хэрэгсэлд хэмжил зүйн төв байгууллагаас олгосон шалгалт баталгаажуулалтын лацаар хэмжих хэрэгслийн эд анги, заалтыг өөрчлөх, тохируулах хэсгийг битүүмжилж, шалгалт баталгаажуулалтын гэрчилгээ олгоно.

2.6.Шалгалт баталгаажуулалтын гэрчилгээ олгохдоо хэмжил зүйн төв байгууллагын даргын баталсан тухайн хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт хоорондын хугацааг баримтална.

2.7.Шалгалт баталгаажуулалтаар стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангаагүй, засварлах, ашиглах боломжгүй нь тогтоогдсон тохиолдолд энэ тухай мэдэгдлийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.

2.8.Шалгалт баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийн дугаар, загвар, хэмжил зүйн үзүүлэлтүүд болон хэрэглэгчийн нэр, хаяг зэргийг тусгасан тэмдэглэл хөтөлнө.

2.9.Программ хангамж ашигладаг хэмжих хэрэгсэл нь MNS OIML D31 стандартын шаардлага хангасан байна. Тухайн хэмжих хэрэгслийг кодоор битүүмжлэх ажлыг улсын шалгагч болон хэмжил зүйн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, түүний эрх бүхий ажилтан хийж нууцыг хадгална. Энэхүү үйл ажиллагааг Хэмжил зүйн төв байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан зохицуулна.

2.10.Хэмжил зүйн байгууллагын хэмжүүр хүлээн авах ажилтан нь шалгалт баталгаажуулалтад хамруулах хэмжих хэрэгслийг хүлээн авч, буцаан олгохдоо хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа, дагалдах хэрэгсэл, эд анги, бүрэн бүтэн байдлыг шалгаж бүртгэл хөтөлнө.

2.11.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт хийж гүйцэтгэхэд шаардагдах шалгалт баталгаажуулалтын төлбөр болон холбогдох зардлыг хүсэлт гаргагч бүрэн хариуцна.

2.12.Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийхэд хэмжил зүйн байгууллагын ажлын эталоны хүчин чадал хүрэлцэхгүй тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллага болон тухайн хэмжих хэрэгслийг ашиглагч, эзэмшигчийн шалгалт тохируулгад хамрагдсан эталоныг ашиглана.

2.13.Хэмжил зүйн байгууллагаас хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг ашиглалтын байранд нь гүйцэтгэх тохиолдолд хүсэлт гаргагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах ажиллах

нөхцөлөөр хангана:

2.13.1.улсын шалгагч, эталон хэмжих хэрэгсэл болон туслах багаж хэрэгслийг шалгалт баталгаажуулалт хийх байранд хүргэх, буцах тээвэрлэлтийг бүрэн хариуцах;

2.13.2.шалгалт баталгаажуулалт хийхэд шаардагдах ажлын байр, туслах ажилтныг гаргаж өгөх;

2.13.3.ажлын эталоныг түр хадгалах өрөө гаргах, битүүмжлэн бүрэн бүтэн байдлыг хангах;

2.13.4.явуулын автомашин лаборатори ашиглах тохиолдолд зогсоол гаргаж, лабораторийг цахилгаан, дулаан, усан хангамжийн эх үүсвэрт холбох.

**Гурав. Шалгалт баталгаажуулалтын төрөл**

3.1.Анхдагч шалгалт баталгаажуулалт

3.1.1.Хэмжих хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох чадавхаа үнэлүүлсэн, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр өмнө нь шалгалт баталгаажуулалтад хамрагдаж байгаагүй хэмжих хэрэгсэлд анхдагч шалгалт баталгаажуулалт хийнэ.

3.1.2.Анхдагч шалгалт баталгаажуулалтыг энэ журмын 3.5-т заасан түүвэр шалгалт баталгаажуулалтын төрлөөр хийж болно.

3.2.Анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх

3.2.1.Аж ахуйн нэгж байгууллага нь импортлох, үйлдвэрлэх хэмжих хэрэгслийн анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрүүлэх бол хүсэлтээ энэ журмын 3.2.2 болон холбогдох стандартад заасан шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг, материалын хамт хэмжил зүйн төв байгууллагад ирүүлнэ.

3.2.2.Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хэмжих хэрэгслийн анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх эсэхийг батлагдсан удирдамж болон дараах шаардлагын дагуу шалгаж, дүгнэлт гаргана. Үүнд:

3.2.2.1.хүсэлт гаргагч аж ахуйн нэгж, байгууллага чадавхаа үнэлүүлж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн байх;

3.2.2.2.хэмжих хэрэгсэл загварын туршилтад тэнцэж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн байх;

3.2.2.3.үйлдвэрлэгч орны хэмжил зүйн байгууллагаас анхдагч баталгаажуулалт хийх эрх авсан, итгэмжлэлийн үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх олон улсын хэлэлцээрт нэгдсэн байгууллагаас итгэмжлэгдсэн үйлдвэрлэгч байх;

3.2.2.4.үйлдвэрлэгчийн анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүн, гэрчилгээ, лац, тэмдэгтэй байх.

3.2.3.Ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийг үндэслэн Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрч хэмжил зүйн төв байгууллага, хүсэлт гаргагч аж ахуйн нэгж, үйлдвэрлэгч хооронд хэмжих хэрэгслийн анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх гэрээг байгуулна.

3.2.4.Анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрсөн хэмжих хэрэгсэл тус бүрийг Хэмжил зүйн төв байгууллагаас олгосон гэрчилгээний дагуу хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлнэ. Гэрчилгээний хураамжийг хүсэлт гаргагч байгууллага хариуцна.

3.2.5.Хэмжих хэрэгслийн анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрсөн гэрээний хугацаа дуусмагц шалгалт баталгаажуулалтыг Хэмжил зүйн байгууллага гүйцэтгэнэ.

3.2.6.Аж ахуйн нэгж, байгууллага нь анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх гэрээний үүргийг зөрчсөн тохиолдолд гэрээг цуцална.

3.3. Ээлжит болон давтан шалгалт баталгаажуулалт

3.3.1.Ээлжит шалгалт баталгаажуулалт нь тогтоосон хугацаанд хэмжих хэрэгслийг баталгаажуулах үйл ажиллагаа бөгөөд баталгаажуулалт хоорондын хугацааг хэмжил зүйн төв байгууллага тогтооно.

3.3.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ашиглалтад байгаа хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалт хоорондын хугацаанд ээлжит шалгалт баталгаажуулалтад хамруулах үүрэг хүлээнэ.

3.3.3.Давтан шалгалт баталгаажуулалтыг лац, тэмдэг нь хөндөгдсөн, арилсан, гэрчилгээг үрэгдүүлсэн хэмжих хэрэгсэлд болон хэрэглэгчийн хүсэлтээр гүйцэтгэнэ.

3.3.4.Хэмжил зүйн төв байгууллагад чадавхаа үнэлүүлж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгуулага хэмжих хэрэгслийг засварлах үйл ажиллагааг эрхлэх ба эвдэрсэн хэмжих хэрэгслийг засварласны дараа давтан шалгалт баталгаажуулалтад хамруулсан байна.

3.4. Магадлан тогтоох шалгалт баталгаажуулалт

3.4.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл гомдол, хүсэлт, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг улсын байцаагч болон улсын шалгагч хамтран хийж, магадлан тогтоох шалгалт баталгаажуулалтын үр дүнг үндэслэн улсын байцаагчийн дүгнэлт гаргана.

3.4.2.Анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг хүлээн зөвшөөрсөн хэмжих хэрэгсэлд магадлан тогтоох шалгалтыг Хэмжил зүйн байгууллага зохион байгуулна.

3.4.3.Хэмжих хэрэгслийн магадлан тогтоох шалгалт баталгаажуулалтыг хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллагын саналыг үндэслэн төлөөллийг байлцуулан гүйцэтгэж болно.

3.4.4.Магадлан тогтоох шалгалт баталгаажуулалтын тайлан, үр дүнг хүсэлт гаргасан байгууллагад ажлын 5-н өдрийн дотор өгнө.

3.5.Түүвэр шалгалт баталгаажуулалт

3.5.1.Түүвэр шалгалт баталгаажуулалтыг хэмжих хэрэгслийн нэг төрлийн багцаас (нэг үйлдвэрлэгчийн, нэг загварын хэмжих хэрэгсэл) 1-р хүснэгтэд заасны дагуу санамсаргүй байдлаар сонгосон, статистикийн хувьд тогтоосон тооны хэмжих хэрэгслээс дээж авч, улсын шалгагч гүйцэтгэнэ.

3.5.2.Ээлжит болон давтан шалгалт баталгаажуулалтын явцад түүвэр шалгалт баталгаажуулалт хийхгүй.

3.5.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь түүвэр шалгалт баталгаажуулалт хийлгэх хүсэлтээ хэмжих хэрэгслийн тоо, хэмжих хэрэгслийн цуврал дугаарын хамт Хэмжил зүйн байгууллагад албан бичгээр ирүүлнэ.

1-р Хүснэгт. Хэмжих хэрэгсэлд түүвэр шалгалт баталгаажуулалт хийхэд дээж авах статистик

| Нэг төрлийн багцад байх хэмжих хэрэгслийн тоо (ширхэг) | Дээж авах шатлал | Дээж-ийн тоо (ширхэг) | Нийт дээж-ийн тоо (ширхэг) | Нийт дээжээс тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо | | Дээж авах хоёрдогч шатлалд шилжих тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо (ширхэг) |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүлээн зөвшөөрөх | Үл хүлээн зөвшөөрөх | |
| 1201-3200 | Анхдагч | 80 | 80 | 2 | 5 | 3 - 4 |
| | Хоёрдогч | 80 | 160 | 6 | 7 | - |
| 3201-10000 | Анхдагч | 125 | 125 | 3 | 6 | 4 - 5 |
| | Хоёрдогч | 125 | 250 | 9 | 10 | - |
| 10001-дээш | Анхдагч | 200 | 200 | 5 | 9 | 6 - 8 |
| | Хоёрдогч | 200 | 400 | 12 | 13 | - |

Тайлбар: Энэ хүснэгтийг ISO 2859-1 Олон Улсын стандартаас иш татсан болно.

3.5.4.Дээж авалт

3.5.4.1.Анхдагч дээж авалтын шалгалтад тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо хүлээн зөвшөөрөх тооноос хэтрээгүй бол нэг төрлийн

багцад байгаа бүх хэмжих хэрэгслийг шалгалтад тэнцсэнд тооцон хэмжих хэрэгсэл бүрийг битүүмжилж, шалгалт баталгаажуулалтын гэрчилгээг олгоно. Энэ тохиолдолд шалгалт баталгаажуулалтын төлбөрийг тухайн багцын бүх хэмжих хэрэгслийг тоогоор тооцно.

3.5.4.2.Анхдагч дээж авалтад тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо нь хүлээн зөвшөөрөх хэмжих хэрэгслийн тооноос их байвал хоёрдогч дээж авалтыг хийнэ.

3.5.4.3.Хоёрдогч дээжийг хүснэгтэд заасан тоогоор анхны багцаас санамсаргүй байдлаар түүвэрлэн улсын шалгагч сонгоно.

3.5.4.4.Нийт дээжээс тэнцээгүй хэмжих хэрэгслийн тоо нь хүлээн зөвшөөрөх тооноос хэтрээгүй бол нэг төрлийн багцад байгаа бүх хэмжих хэрэгслийг шалгалтад тэнцсэнд тооцон хэмжих хэрэгсэл бүрийг битүүмжилж, шалгалт баталгаажуулалтын гэрчилгээ олгоно.

3.5.4.5.Түүвэр шалгалт баталгаажуулалтаар анхдагч болон хоёрдогч дээжийн тэнцээгүй хэмжих хэрэгслийн нийлбэр тоо хүлээн зөвшөөрөх тооноос их байвал багцын бүх хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулалт хийнэ.

**Дөрөв. Шалгалт баталгаажуулалт хийх гэрээ**

4.1.Хэмжил зүйн байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагатай тухайн жилд хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулах гэрээг байгуулна.

4.2.Гэрээний загварыг Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Хэмжил зүйн төв байгууллага” гэх) батална.

4.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь батлагдсан загварын дагуу гэрээний төслийг төлөвлөгөөний хамт 3 (гурав) хувь боловсруулж, өмнөх оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор холбогдох хэмжил зүйн байгууллагатай байгуулна.

4.4.Хэмжил зүйн чадавхын анхдагч үнэлгээнд хамрагдсан аж ахуйн нэгж байгуулага нь батлагдсан загварын дагуу гэрээний төслийг төлөвлөгөөний хамт 3 (гурав) хувь боловсруулж тухайн онд хэмжил зүйн байгууллагатай байгуулна.

4.5.Аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээнд өөрчлөлт оруулах бол гэрээний хугацаа дуусахаас ажлын 20 хоногийн өмнө хэмжил зүйн байгууллагад өөрчлөлт оруулах санал, гэрээний төслийн хамт албан бичгээр ирүүлнэ.

4.6.Гэрээнд  шалгалт баталгаажуулалтад хамруулах хэмжих хэрэгслийн хэмжил зүйн үзүүлэлт, тоо ширхэг, хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөр, шалгалт баталгаажуулалт хийх газар, он, сар, өдөр болон холбогдох зардлыг тодорхой тусгана.

4.7.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын гэрээний биелэлтийг холбогдох журмын дагуу талууд хамтран дүгнэнэ.

**Тав. Хэмжих хэрэгслийн ашиглалтад хяналт тавих**

5.1.Хэмжих хэрэгслийн ашиглалтад тавих хяналтыг Хэмжил зүйн байгууллага, улсын шалгагч хийх ба аж ахуйн нэгж, байгууллага өөрийн дотоод хяналтыг тавина.

5.2.Хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулсны дараа баталгааны лац, тэмдэг хөндөгдсөн, гэрчилгээний хүчинтэй хугацаа, хэмжил зүйн үзүүлэлт нь холбогдох стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд ашиглалтын хяналтыг тавина.

**Зургаа. Шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих**

6.1.Энэ журмын хэрэгжилтэд хэмжил зүйн төв байгууллагын эрх бүхий албан тушаалтан хяналт тавина.

**Долоо. Хүлээлгэх хариуцлага**

7.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 7483 дугаарт бүртгэв.*

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 482 | Улаанбаатар хот |

## “ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ” БАТЛАХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2, 63.1.22 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын 1-д заасан журмыг 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан өөрийн байгууллагын дүрэм, журамд зохих өөрчлөлтийг оруулж, энэ тогтоолын 2-т заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулахыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн, төлбөр тооцооны, клирингийн, арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд, журмын хэрэгжилтийг хангаж, мөрдөн ажиллахыг нийт зохицуулалттай этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА Т.ЖАМБААЖАМЦ

*Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 482 дугаар тогтоолын хавсралт*

# ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд тавих шаардлага, зээлдүүлж болох үнэт цаасны төрөл, гэрээний нөхцөл, барьцаа хөрөнгийн удирдлага, оролцогч талуудын эрх, үүрэг, мэдээллийн тайлагналтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад хамаарахгүй хязгаарлагдмал хариуцлагатай компани, хаалттай хувьцаат компанийн үнэт цаас, зохицуулалттай зах зээлд арилжаалахыг зөвшөөрөөгүй бусад төрлийн үнэт цаасыг зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

## ХОЁР. ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

2.1.Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой хэлцлийг зохион байгуулах, барьцаа хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, өдөр тутмын үнэлгээ болон эрсдэлийн менежмент хийх, гэрээ болон холбогдох баримт бичгийг баталгаажуулж хадгалах, мэдээлэл тайлагнах зэрэг үйл ажиллагааг дараах этгээд хэрэгжүүлнэ:

2.1.1.Үнэт цаасны номиналь дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан Үнэт цаасны компани (цаашид “ҮЦК” гэх);

2.1.2.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага (цаашид “ҮЦТХТ” гэх).

2.2.ҮЦТХТ, ҮЦК нь энэ журмын 3.1-д заасан гэрээг байгуулахаас өмнө зээлдэгчийг таньж мэдэх, түүний санхүүгийн чадамж, барьцаа хөрөнгө, хөрөнгө оруулалтын туршлагыг хянасны үндсэн дээр үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээг үзүүлнэ.

2.3.ҮЦК үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэхдээ өмчлөх эрх нь өөрийн нэр дээр бүртгэлтэй үнэт цаасыг зээлдүүлнэ.

2.4.ҮЦК өөрийн харилцагчаас зээлдэж авсан үнэт цаасыг бусад харилцагчид зээлдүүлэх үнэт цаасны сагсыг бүрдүүлэх зорилгоор үнэт цаас зээлдэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлж болно.

2.5.ҮЦК энэ журмын 2.4-т заасны дагуу харилцагчаас зээлдэж авсан үнэт цаасыг зээлдүүлэх тохиолдолд тухайн харилцагчийн зөвшөөрлийг тухай бүр урьдчилан авч, энэ журмын 3.1-д заасан гэрээг

байгуулна.

2.6.ҮЦТХТ, ҮЦК нь үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг Хорооноос баталсан “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-т заасан шаардлагыг хангасан харилцагчид үзүүлнэ.

2.7.ҮЦК нь кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ үзүүлсэнтэй холбогдуулан харилцагчийн өмчлөх эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлүүлнэ.

2.8.Зээлдүүлэгч нь нээлттэй арилжаалагддаг Засгийн газар, аймаг, нийслэлийн үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагын бонд, компанийн бонд, хувьцаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хамтын хаалттай сангийн нэгж эрх, үнэт цаасны зах зээлд арилжаалахаар гаргасан хадгаламжийн сертификатыг зээлдүүлнэ.

2.9.Зээлдэгч дангаараа, эсхүл холбогдох этгээдтэй хамтран нээлттэй арилжаалагддаг хувьцааг зээлдэж авсны дараагаар эзэмших хэмжээ нь хувьцааны хяналтын багцаас хэтрэхгүй байна.

2.10.Зээлдэгч нь нээлттэй арилжаалагддаг компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч тохиолдолд зээлдүүлэгчээс тус компанийн хувьцааг зээлдэн авч шорт арилжаа хийхгүй.

2.11.ҮЦТХТ, ҮЦК нь зээлдүүлэх боломжтой үнэт цаасны талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.

2.12.Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбогдсон нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг тогтоож, Хороогоор батламжлуулна.

## ГУРАВ. ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

3.1.Зээлдүүлэгч болон зээлдэгч талууд “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх гэрээ” (цаашид “гэрээ” гэх)-г Олон улсын үнэт цаас зээлдүүлэх холбоо (ISLA)-ны зарчмуудад тулгуурлан харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулах бөгөөд уг гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:

3.1.1.талуудын албан ёсны нэр, хаяг, иргэний бүртгэлийн дугаар, иргэн, хуулийн этгээдийн регистрийн дугаар болон бусад шаардлагатай мэдээлэл;

3.1.2.зээлдүүлэх үнэт цаасны төрөл, тоо хэмжээ, төрөл тус бүрийн болон нийт үнийн дүн;

3.1.3.зээлийн хугацаа;

3.1.4.барьцаа хөрөнгийн болон барьцаа хөрөнгө үнэт цаас байх тохиолдолд хорогдуулалтын хувь;

3.1.5.үйлчилгээний шимтгэлийн хувь хэмжээ, төлөх давтамж, тооцож эхлэх хугацаа;

3.1.6.барьцаанд тавьсан мөнгөн хөрөнгийг хадгаламжид байршуулах тохиолдолд хүү тооцож эхлэх болон дуусах өдөр;

3.1.7.талуудын эрх, үүрэг, хариуцлага.

3.2.Зээлдүүлэгч үнэт цаасыг зээлдэгчид шилжүүлж, зээлдэгч барьцаа хөрөнгийг барьцаалуулснаар тухайн гэрээ хүчин төгөлдөр болно.

3.3.Гэрээнд дараах анхааруулгыг тодоор бичсэн байна:

“Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд зээлдэгч тал гэрээнд заасан хугацаанд зээлдүүлсэн үнэт цаасыг буцаан нийлүүлэх үүргээ биелүүлж чадахгүй болох, улмаар зээлдүүлсэн үнэт цаасаа бүрэн хэмжээгээр буцаан авч чадахгүй болох ЭРСДЭЛТЭЙ үйлдэл гэдгийг онцгойлон анхаарч, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд оролцохоосоо өмнө холбогдох эрсдэл, нөхцөлийг сайтар судалж, өөрийн санхүүгийн боломжид тулгуурлан зээлдүүлэх шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

3.4.Зээлдүүлсэн үнэт цаасны хүүгийн орлого, хувьцааны ногдол ашиг, саналын эрх зэрэг өмчлөх эрхтэй холбоотой тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх эрх гэрээний хугацаанд зээлдэгчид шилжинэ.

3.5.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд ҮЦК нь гэрээний хуулбарыг ҮЦТХТ, эсхүл кастодианд тухай бүр хүргүүлнэ.

3.6.Гэрээнд өөрөөр заагаагүй бол зээлдэгч нь зээлдэж авсан үнэт цаастай холбоотой аливаа шимтгэл, хураамж болон бусад холбогдох зардлыг өөрөө хариуцах бөгөөд зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгөтэй холбогдох зардлыг хариуцна.

## ДӨРӨВ. БАРЬЦАА ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

4.1.Зээлдэгч нь зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшид суурилан үнэт цаасыг эргэн төлөх баталгаа болгон барьцаа хөрөнгийг байршуулах бөгөөд барьцаа хөрөнгө нь бэлэн мөнгө, нээлттэй арилжаалагддаг Засгийн газар, аймаг, нийслэлийн үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан бонд, компанийн бонд, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын I ангилалд бүртгэлтэй компанийн хувьцаа, үнэт цаасны зах зээлд арилжаалахаар гаргасан хадгаламжийн сертификат болон аккредитиваас бүрдэнэ.

4.2.Энэ журмын 4.1-т заасан барьцаа нь мөнгөн хөрөнгө, эсхүл аккредитив байх тохиолдолд зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшаас багагүй, эсхүл үнэт цаас хэлбэртэй байх тохиолдолд зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшаас дээш дүнтэй байх бөгөөд энэ тохиолдолд хорогдуулалтын хувь хэмжээг гэрээнд тусгана.

4.3.ҮЦТХТ, ҮЦК нь зээлдүүлсэн үнэт цаасны зах зээлийн ханшид үндэслэн барьцаа хөрөнгийн үнэлгээг өдөр тутам тооцоолох бөгөөд барьцаа хөрөнгийн үнэлгээ багассан тохиолдолд нэмэлт барьцаа байршуулахыг зээлдэгчээс шаардана.

4.4.Зээлдэгч болон зээлдүүлэгч хоорондоо тохиролцсон бол зээлдэгч нь зээлээр авсан үнэт цаасаа буцаан олгох хүртэл зээлдүүлэгч нь барьцаанд байгаа бэлэн мөнгийг арилжааны банкны тусгайлан нээсэн харилцах, эсхүл мөнгөн хадгаламжийн дансанд тусад нь хадгалуулах бөгөөд мөнгөн хадгаламжид хадгалуулах тохиолдолд хадгаламжийн хүүгийн орлогын хэмжээ, төлбөрийн нөхцөлийг талууд тохиролцсоны үндсэн дээр гэрээнд тодорхой заана.

4.5.Барьцаа хөрөнгө нь үнэт цаас хэлбэртэй байх тохиолдолд тухайн барьцаа хөрөнгийг тусгаарлах үйл ажиллагааг ҮЦТХТ, эсхүл кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд гүйцэтгэнэ.

4.6.ҮЦТХТ нь энэ журмын 4.5-д заасан барьцаа хөрөнгийг тусгаарлахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг тогтоож, Хороогоор батламжлуулна.

4.7.Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь энэ журмын 4.5-д заасан барьцаа хөрөнгийг тусгаарлахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг боловсруулж, Хорооны саналыг авч тусгасны үндсэн дээр үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

## ТАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1.Зээлдүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй байна:

5.1.1.талууд гэрээгээр тохиролцсон бол зээлдүүлсэн үнэт цаастай холбоотой ногдол ашиг, хүүгийн орлого зэрэг тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх;

5.1.2.барьцаа хөрөнгийн үнэлгээ анх байршуулсан дүнгээс бага болсон тохиолдолд зээлдэгчээс нэмэлт барьцаа байршуулахыг шаардах;

5.1.3.зээлдэгч төлбөрийн чадваргүй, эсхүл гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд барьцаа хөрөнгийг захиран зарцуулж, зээлдүүлсэн үнэт цаасыг дахин худалдан авахад ашиглах.

5.2.Зээлдэгч нь дараах эрх, үүрэгтэй байна:

5.2.1.гэрээнд заасан нөхцөлийн дагуу зээлдэж авсан үнэт цаасыг тодорхой хугацаанд ашиглах, зээлдүүлэгчид буцаан олгох;

5.2.2.зээлж авсан үнэт цаасыг эргэн төлөх баталгаа болгон зээлдүүлэгчийн шаардсан барьцаа хөрөнгийг гэрээнд заасны дагуу байршуулах;

5.2.3.шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээ анх байршуулсан барьцаа хөрөнгийн хэмжээнээс буурсан тохиолдолд нэмэлт барьцаа хөрөнгө байршуулах;

5.2.4.зээлж авсан үнэт цаастай холбоотой ногдол ашиг, хүүгийн орлого, саналын эрх зэрэг тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх;

5.2.5.барьцаанд тавьсан үнэт цаасны хүү, ногдол ашгийн орлого болон саналын эрх зэрэг үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх;

5.2.6.гэрээгээр тохиролцсон мэдээллийг зээлдүүлэгчид гаргаж өгөх;

5.2.7.гэрээ дуусгавар болох, эсхүл аль нэг талын санаачилгаар гэрээг цуцлах үед зээлж авсан үнэт цаасыг зээлдүүлэгчид буцаан шилжүүлэх;

5.2.8.барьцаанд тавьсан үнэт цаасыг давхар барьцаалахгүй байх;

5.2.9.үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбогдон үүсэж болзошгүй эрсдэлийн талаарх мэдээлэлтэй урьдчилан танилцсан байх.

5.3.ҮЦТХТ, ҮЦК нь дараах эрх, үүрэгтэй байна:

5.3.1.үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэх тухай нарийвчилсан журамтай байх;

5.3.2.үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай шуурхай, тасралтгүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон программ хангамжтай байх;

5.3.3.зээлийн эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээг өдөр бүр тооцоолох;

5.3.4.үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой гэрээ, заавар, баримт бичиг болон холбогдох бусад бүртгэлийг цахим болон цаасан хэлбэрээр хадгалах.

## ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

6.1.ҮЦТХТ, ҮЦК нь үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой дараах мэдээллийг Хороонд доор дурдсан хугацаанд цахимаар хүргүүлнэ:

6.1.1.үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой оролцогч талууд хооронд байгуулсан гэрээ, гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг дараа сарын 10-ны өдрийн дотор;

6.1.2.энэ журмын хавсралтаар баталсан үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд хийгдсэн хэлцлийн сар бүрийн мэдээллийг дараа сарын 05-ны өдрийн дотор;

6.1.3.үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой үйлчилгээний шимтгэлийн хувь, түүнд өөрчлөлт орсон бол шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор;

6.1.4.зээлдэгч гэрээний үүргээ биелүүлээгүй, үнэт цаасаа буцаан өгөх чадваргүй болсон тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр;

6.1.5.үнэт цаас зээлдэх, зээлдүүлэх гэрээтэй холбоотой маргаан шүүх, хяналтын байгууллагад шилжсэн тохиолдолд тухай бүр.

*“Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай журам”-ын хавсралт*

Хүснэгт а. ҮЦК-ийн үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд хийгдсэн хэлцлийн мэдээлэл

| Д/д | ҮЦК-ийн албан ёсны нэр | ҮЦК-ийн регистрийн дугаар | Харилцагчийн нэр дээрх үнэт цаасыг шилжүүлж авса н эсэх | Харилцагчийн мэдээлэл | | Зээлдэгч талын албан ёсны нэр | Иргэн/ хуулийн этгээдийн бүртгэлийн/ регистрийн дугаар | Үнэт цаасны төрөл | Үнэт цаасны нэр | Тоо хэмжээ | Үйлчилгээний хугацаа | Үйлчилгээний шимтгэлийн хүү | Барьцаа хөрөнгийн мэдээлэл | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Иргэн/Хуулийн этгээдийн нэр | Иргэн/ хуулийн этгээдийн бүртгэлийн/ регистрийн дугаар | | | | | | | | Үнэт цаас | Бэлэн мөнгө | Аккре-дитив |
| | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | |
| .... | | | | | | | | | | | | | | | |

Хүснэгт б. ҮЦТХТ-ийн үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд хийгдсэн хэлцлийн мэдээлэл

| Д/д | Зээлдүүлэгч талын албан ёсны нэр | Иргэн/ Хуулийн этгээдийн регистрийн дугаар | Зээлдэгч талын албан ёсны нэр | Иргэн/ Хуулийн этгээдийн регистрийн дугаар | Үнэт цаасны төрөл | Үнэт цаасны нэр | Тоо хэмжээ | Үйлчил-гээний хугацаа | Үйлчилгээний шимтгэлийн хүү | Барьцаа хөрөнгийн мэдээлэл | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Үнэт цаас | Бэлэн мөнгө | Аккре-дитив |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| ..... | | | | | | | | | | | | |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 7484 дүгээрт бүртгэв.*

# ДОРНОГОВЬ АЙМАГ АЛТАНШИРЭЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 06/31 Чулуунгишгэр

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын малчин болон мал бүхий өрхийн нэг малын тоо толгойд ноогдох албан татварын хэмжээг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Захиргааны хэм хэмжээний актыг Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлэхийг сумын Засаг дарга (Б.Ган-Од)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (М.Баярцэцэг)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6754 дугаарт бүртгэлтэй байгаа сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 16/01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Н.САРАНГОО

*Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын*
*2026 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн*
*06/31 дүгээр тогтоолын хавсралт*

## АЛТАНШИРЭЭ СУМЫН МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

| № | Малын төрөл | Татварын хэмжээ |
|---|---|---|
| 1 | 2 | 3 |
| 1 | Тэмээ | 0 |
| 2 | Адуу | 0 |
| 3 | Үхэр | 0 |
| 4 | Хонь | 600 |
| 5 | Ямаа | 600 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 7485 дугаарт бүртгэв.*

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр　　Дугаар 08/04　　Зүлэгт

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалт, 68 дугаар зүйлийн 68.1 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Иххэт сумын малчин болон мал бүхий өрхийн нэг малын тоо толгойд ногдох албан татварын хэмжээг тэмээ-300, адуу-300, үхэр-300, хонь-200, ямаа-200 төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2.Тогтоолыг холбогдох байгууллагад хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлэхийг сумын Засаг дарга (Б.Содмагнай)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Дэд бүтэц, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооны дарга (С.Алтанбагана), Нарийн бичгийн дарга (С.Ганчимэг) нарт даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 7247 дугаарт бүртгэлтэй байгаа сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 04/03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА　　Б.БАТ-ОД

[illegible]

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
Бүртгэлийн дугаар 02
ХУУЛБАР ХУВЬ
(Албан тушаалын нэр)
С. Ганчимэг
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2025 оны 12-р сарын 19-ны өдөр

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 7486 дугаарт бүртгэв.*

# СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр　　Дугаар 06　　Сэргэлэн

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭГ ӨӨРЧЛӨН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ээлжит 8 дугаар хурлаас ТОГТООХ нь:

1.Түвшинширээ суманд 2023-2024 онуудад байгаль цаг агаарын хүнд нөхцөл байдлын улмаас мал эрс цөөрч малчин болон мал бүхий иргэдийн амьжиргаа хүнд байгаа тул малын тоог өсгөх зорилгоор 2026 оны малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг Тэмээ 0, Адуу 0, Үхэр 0, Хонь 0, Ямаа 0 төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2.Уг тогтоол хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 09 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Малын тоо толгойн албан татварыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг Сумын Засаг дарга (Н.Мөнхбаяр), Татварын Улсын байцаагч (Л.Отгонцэнд) нарт үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт даалгасугай.

ДАРГА　　Д.БАТТУЛГА

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 7487 дугаарт бүртгэв.*

# СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр    Дугаар 06    Овоот

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 68 дугаар зүйлийн 68.1 дэхь хэсгийг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ээлжит VII дугаар хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.2024 онд Сумын хэмжээнд өвөлжилт хаваржилт хүндэрч байгалийн гамшигт үзэгдлийн улмаас малчдын амжиргааны түвшин эрс буурсан, зудын хямралаас бүрэн гараагүй, 2025 оны төлийн бойжилт хангалтгүй тул 2026 онд ногдуулах малын тоо толгойн албан татварыг Адуу -0, үхэр-0, тэмээ-0, хонь-0, ямаа-0 төгрөгөөр тус тус тогтоосугай.

2.Татварын хувь хэмжээг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд холбогдох журмын дагуу бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Б.Чулуунчимэг)-т үүрэг болгосугай.

3.2021, 2022, 2023 оны Малын тоо толгойн албан татварын үлдэгдэл 138,0 сая төгрөгний татварыг төсөвт төвлөрүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жилээр тайлагнахыг Татварын байцаагч (Ү.Сувдмаа)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороонд үүрэг болгосугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2024 оны 12 дүгээр сарын 25-ний өдрийн 06 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА    Б.ГАНБОЛД

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд*
*2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 7488 дугаарт бүртгэв.*

# СҮХБААТАР АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар А/18 | Баруун-Урт

## “АСГАТ УЛААН ДЭЛ” ОНӨААТҮГ-ЫН ТАРИФЫГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь заалт, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор батлагдсан журам, “Асгат улаан дэл” ОНӨААТҮГ-ын 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Асгат сумын “Асгат улаан дэл” ОНӨААТҮГ-ын эзэмшил дэх дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Асгат улаан дэл” ОНӨААТҮГ-ын дарга /Ц.Ариунбаатар/-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг Зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /Ш.Мандахнар/-д даалгасугай.

ДАРГА Ш.МАНДАХНАР

ГИШҮҮД Г.СУГАРАА
Б.МӨНХСҮЛД

*Сүхбаатар аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн*
*2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн*
*А/18 дугаар тогтоолын хавсралт 1*

## “АСГАТ УЛААН ДЭЛ” ОНӨААТҮГ-ЫН ЭЗЭМШИЛ ДЭХ ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

Сүхбаатар аймгийн Асгат сумын “Асгат улаан дэл” ОНӨААТҮГ-ын эзэмшил дэх дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон тус сумын хэрэглэгчид /төсөвт байгууллага/-д борлуулах дулааны эрчим хүчний тариф /НӨАТ-гүй/-ыг дараах байдлаар тогтооно.

| Д/Д | ХЭРЭГЛЭГЧДИЙН АНГИЛАЛ | | ХЭМЖИХ НЭГЖ | ТАРИФ /НӨАТ-гүй/ |
|---|---|---|---|---|
| 1. | Төсөвт байгууллагуудын халаалт | | Төг/м3 | 2830 |
| 2 | Төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн хэмжүүрээр тооцох халаалт | Хувьсах | Төг/ГЖ | 19397,65 |
| | | Тогтмол | Төг/м3 | 1850,64 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 7489 дүгээрт бүртгэв.*

# БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД, БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ШИЙДВЭР

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар А/864, А/641 | Баянхонгор

## АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС ТОГТООХ, БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 72 дугаар зүйлийн 72.1.1, 72.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн Баянхонгор хотын “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг 1 дүгээр, бүсэд мөрдөх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Энэхүү хамтарсан тушаал, захирамжийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, журмыг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга (Г.Энхмөнх)-д, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын дарга (Б.Бат-Өлзий), Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Ч.Оюунчимэг), Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч (М.Насанбат)-д тус тус үүрэг болгосугай.

3.Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчны газрын дарга (Б.Бат-Өлзий), Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч (М.Насанбат)-д тус тус даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД Б.БАТБААТАР

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд,
Баянхонгор аймгийн Засаг даргын хамтарсан
2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
А/864, А/641 дүгээр тушаал, захирамжийн
1 дүгээр хавсралт*

## БАЯНХОНГОР ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС

| Бүс | Бүсэд хамрагдах баг | Өрхийн тоо | Аж ахуйн нэгж байгууллага | Эзлэх талбай |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1-р бүс<br>4, 5, 6 багийн айл өрх, албан байгууллагууд хамрагдана | 4, 5, 6-р баг | 3365 | 34 | 275.1 га |



*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд,
Баянхонгор аймгийн Засаг даргын хамтарсан
2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
А/864, А/641 дүгээр тушаал, захирамжийн
2 дугаар хавсралт*

# БАЯНХОНГОР ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС, БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ

## Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Баянхонгор аймгийн Баянхонгор хотын агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэүү журмыг Баянхонгор хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

## Хоёр.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүрэг

Баянхонгор хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагууд нь агаар бохирдуулагч аливаа эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр дүгнэлт гаргуулан Баянхонгор сумын Засаг даргаас зөвшөөрөл авах;

2.2.Агаарын чанарыг сайжруулах бүсэд халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд технологийн шинэчлэл хийж сайжруулах, шаталтыг бүрэн явуулах, бохирдлыг бууруулах зорилгоор /тортог баригч шүүлтүүр, утаа сарниулагч суурилуулах, зуухны янданг боломжит хамгийн өндөр хэмжээнд хүртэл өндөрлөх г.м/ тоноглох;

2.3.Уурын болон усан халаалтын зуух, яндангийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийж үнс, нурам ачиж тээвэрлэхдээ тоосжилт дарах /чийгшүүлэх/ арга хэмжээ авах;

2.4.Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага халаалтын зууханд хаягдал дугуй, ашигласан масло, хуванцар хог, нийлэг уут гэх мэт зориулалтын бус түлш шатаахгүй байх;

2.5.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах иргэн 5-аас доошгүй, аж ахуйн нэгж байгууллагууд 10-аас доошгүй мод бутыг өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайд тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

2.6.Агаарын чанарыг сайжруулах бүсэд аймаг, сумаас зохион байгуулж буй сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох;

2.7.Агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс эрүүл мэндээ хамгаалах зорилгоор дотоод орчны агаарын чанараа сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.8.Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрхүүд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвших;

2.9.Гэр хорооллын айл өрхүүд ариун цэврийн байгууламжаа нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага MNS 5924:2015 стандартад нийцүүлэх;

2.10.Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд өдөр шөнийн 2 тарифт тоолуур суурилуулах, шөнийн цагаар түүхий нүүрс түлэхээс татгалзаж, цахилгаан халаагуур болон бусад дэвшилтэд технологи бүхий бүтээгдэхүүн (Гэр, байшин барилгын дулаан алдагдлыг багасгах, сайжруулсан зуух, түлш, сэргээгдэх эрчим хүч, хийн түлш гэх мэт)-ийг хэрэглээндээ үе шаттайгаар нэвтрүүлэх;

2.11.Байгаль орчны газрын байцаагч болон цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, байгаль орчны мэргэжилтнийг шаардлагатай тохиолдолд өөрийн эзэмшилд нэвтрүүлж, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

2.12.Агаарын чанарын талаарх мэдээлэл болон агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

2.13.Агаарын чанарыг сайжруулах бүсэд 15кВт хүртэлх хүчин чадалтай зуухны тоог нэмэгдүүлэхгүй байх;

2.14.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн аж ахуй нэгжүүд 15-100 кВт хүртэлх хүчин чадалтай зууханд технологийн шинэчлэлт хийх /хийн болон цахилгаан/;

2.15.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй 101 кВт-аас хүчин чадалтай зуухны үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий Хүхрийн давхар исэл, Азотын давхар исэл, Тоосонцор шүүх шүүлтүүрүүдийг суурилуулах;

2.16.Агаарын чанарыг сайжруулах бүсэд Гэр сууц, ажлын байрны дулаан алдагдлыг багасгах зориулалттай, стандартад нийцсэн нэмэлт дулаалга хийх.

**Гурав.Төрийн байгууллагуудын чиг үүрэг**

3.1.Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

3.2.Аймгийн Байгаль орчны газар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын

хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.3.Багийн Засаг дарга нар агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрх болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг гаргаж, дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвд хүргүүлнэ.

3.4.Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь агаарын чанарыг сайжруулах бүсэд орших агаар бохирдуулах эх үүсвэрийн мэдээлэл болон агаарын чанарын төлөв байдлын талаарх тайлан мэдээг Байгаль орчны газар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт хагас, бүтэн жилээр хүргүүлнэ.

3.5.“Цэвэр хот” ОНӨАТҮГазар гэр хорооллын айл өрхийн ангилан ялгасан үнс, ахуйн хог хаягдлыг гарагийн хуваарийн дагуу ангилж тээвэрлэнэ.

3.6.Түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй байгалийн хий болон цахилгаан халаалтыг өргөнөөр нэвтрүүлэхийг сурталчлан таниулах, сургалт сурталчилгаа хийх.

3.7.Байгаль орчны газар “Агаарын тухай хууль тогтоомж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр баримталж буй төрийн бодлого, шийдвэр”-ийн хүрээнд иргэн аж ахуйн нэгж байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.8.Өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэрэглээг хэвшүүлэх сурталчилгааг Эрүүл мэндийн газар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулна.

3.9.Байгаль орчны газар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газартай хамтран журмын хэрэгжилтийн талаар холбогдох мэдээ тайланг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

**Дөрөв.Хяналт, хариуцлага**

4.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Баянхонгор аймгийн Байгаль орчны газар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, сум, багийн Засаг дарга нар хяналт тавина.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль (Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг), төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 7490 дугаарт бүртгэв.*

# МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар А/356 | Улаанбаатар хот |

## ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Мал, амьтны эмийг жороор олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг сурталчлан таниулах, хэрэгжүүлж ажиллахыг Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга (Б.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын дарга (Б.Батсүх)-д даалгасугай.

4.Энэхүү журам батлагдсантай холбогдуулж Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/426 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА А.НАРАНТУЯА

*Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
А/356 дугаар тушаалын хавсралт*

# МАЛ, АМЬТНЫ ЭМИЙГ ЖОРООР ОЛГОХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх эмийн үлдцийн хяналтыг сайжруулах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх харилцааг зохицуулахад мал, амьтны эмийг жороор олгох журмын зорилго оршино.

1.2.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 6.4-т заасны дагуу Мал, амьтны эмийн улсын бүртгэлд жороор олгохоор заагдсан мал, амьтны эмд жор бичих, олгох, хэрэглэх үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.3.Энэ журмыг бүх шатны мал эмнэлгийн байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, гэрээт болон аж ахуйн нэгжийн малын эмч, мал, амьтны эм ханган нийлүүлэх байгууллага, мал, амьтны эмийн сан болон малчин, мал, амьтан бүхий иргэд дагаж мөрдөнө.

1.4.Жороор олгох эмд мал, амьтны биед болон тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үлдэц үүсгэдэг, өвчин үүсгэгч бичил биетэнд тэсвэржилт үүсгэх эрсдэлтэй, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм тус тус хамаарна.

1.5.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 13.7.3-д заасны дагуу эмийн санд жороор олгох эмийг жоргүйгээр, эсхүл стандартын бус жороор олгох, 14.1.3-т заасны дагуу малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч хүн, хуулийн этгээдэд жороор олгох эмийг малын эмчийн зөвшөөрөлгүй мал, амьтанд хэрэглэхийг тус тус хориглоно.

1.6.Энэ журмын 1.2-т зааснаас бусад мал, амьтны эмийг худалдах, хэрэглэхэд энэ журам үйлчлэхгүй.

## Хоёр. Журмын нэр томьёо

2.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.”Ханган нийлүүлэх байгууллага” гэж Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасныг,

2.1.2.“Мансууруулах эм” гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.4 дэх заалтад заасныг,

2.1.3.”Сэтгэцэд нөлөөт эм” гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.5 дахь заалтад заасныг,

2.1.4.“Мал, амьтны эмийн жор” гэж Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 13.7.3 дахь заалтын тайлбар хэсэгт заасныг.

## Гурав. Жорын хэлбэр, төрөл

3.1.Мал, амьтны эмийн жор нь цахим болон цаасан хэлбэртэй байна.

3.2.Мал, амьтны эмийн жор нь энгийн эмийн жор болон тусгай эмийн жор гэсэн төрөлтэй байна.

3.3.Мал, амьтны Эмийн зөвлөл нь Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлд заасны дагуу мал, амьтны эмийг жороор олгох эсэхийг тогтоохдоо энгийн эмийн жор болон тусгай эмийн жороор олгох эм гэж ангилан заана.

Тайлбар: “Тусгай эмийн жор” гэж энэхүү журмын 2.1.2, 2.1.3-т заасан эмийн жорыг, “Энгийн эмийн жор” гэж тусгай эмийн жороор олгохоос бусад жороор олгох эмийн жорыг ойлгоно.

3.4.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30.20-д заасан журмын дагуу итгэмжлэлтэй мал, эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (цаашид “малын эмч” гэх) нь тухайн өвчтэй мал, амьтанд эмнэлзүйн үзлэг хийж, онош тогтоосны дараа, шаардлагатай бол лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн эмийг бэлтгэх, олгох, хэрэглэх аргыг заасан мал, амьтны эмийн жорыг бичнэ.

3.5.Энэ журмын 3.4-т заасны дагуу малын эмийн жор нь Монгол Улсын хэмжээнд хүчинтэй байна.

## Дөрөв. Цаасан жор

4.1.Цахим системд нэвтрэх боломжгүй нөхцөлд малын эмч цаасан жор бичиж болно.

4.2.Мал, амьтны эмийн цаасан жорыг олгохдоо журмын маягт 1 /Энгийн эмийн жорын маягт/, маягт 2 /Тусгай эмийн жорын маягт/-ын дагуу үйлдэж, ашиглана.

4.3.Малын эмч эмийн жорыг цаасаар бичсэн тохиолдолд бүртгэл хөтөлнө.

## Тав. Цахим жор

5.1.Мал, амьтны эмийн цахим жорыг мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ийг ашиглан бичнэ;

5.2.Малын эмч нь цахим системд бүртгүүлсний дараа цахим жор бичих эрх үүснэ;

5.3.Цахим жор бичих, олгох цахим системийн үйл ажиллагааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна;

5.4.Цахим системд энэ журмын дагуу жорыг үүсгэхэд шаардлагатай мэдээллийг сонгох, эсхүл сонголт хийх боломжгүй бол мэдээллийг бичиж оруулна;

5.5.Мал, амьтны эм ханган нийлүүлэх байгууллагаас худалдан авсан жороор олгох эмийг худалдан борлуулсан, зарцуулалтын талаарх эмийн нэр, тоо хэмжээний мэдээллийг мал, амьтны эмийн сангийн захирал эсвэл тухайн эмийн сангийн эрх бүхий малын эмч цахим системд тухай бүр бүртгэнэ;

5.6.Мал, амьтны эм ханган нийлүүлэх байгууллага болон малын эмийн үйлдвэр нь жороор олгох мал, амьтны эмийг эмийн сан, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид худалдсан тухай бүр эмийн нэр, тоо хэмжээг цахим системд бүртгэнэ;

5.7.Энгийн эмийн жорыг мал, амьтны эзний хүсэлтээр цахим системээс хэвлэн өгч болно

## Зургаа. Энгийн эмийн жорын мэдээлэл

6.1.Энгийн эмийн жор нь дараах мэдээллийг агуулна:

6.1.1.Мал, амьтны эзний овог, нэр, гэрийн хаяг, утасны дугаар, мал, амьтны төрөл, үүлдэр, зүс, нас, хүйс, мал, амьтны бүртгэлийн дугаар /байгаа бол/;

6.1.2.Эмийн ерөнхий нэршил (гол үйлчлэгч бодисын нэр);

6.1.3.Эмийн хэлбэр, тун, давтамж;

6.1.4.Эм хэрэглэх арга, хугацаа;

6.1.5.Эмийг бодис мал, амьтны биеэс гадагшлах хугацаа;

6.1.6.Жор бичсэн эмчийн харьяалах мал, эмнэлгийн нэгжийн, эсхүл хуулийн этгээдийн нэр, эмчийн нэр, итгэмжлэлийн дугаар, жор бичсэн огноо;

6.2.Энгийн эмийн жор нь дор дурдсан агуулга бүхий анхааруулга хэсэгтэй байна.

6.2.1.Хүнсний зориулалттай мал, амьтны биеэс хэрэглэсэн эм бүрэн гадагшлах хугацаа дуусаагүй байхад мал, амьтныг төхөөрөхгүй ба мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн (сүү, өндөг г.м)-ийг хүнсэнд ашиглахгүй.

## Долоо. Тусгай эмийн жорын мэдээлэл

7.1.Тусгай эмийн жор нь энэ журмын 6.1-д зааснаас гадна дараах мэдээллийг агуулна:

7.1.1.зориулалт;

Тайлбар: Зориулалт хэсэгт тухайн мал, амьтныг тайвшруулах, мэдээгүйжүүлэх, эмжүүлэх, өвдөлт намдаах, эсхүл нэг эмийнхээ үйлчлэлийг дэмжих г.м-ээр бичнэ.

7.1.2.Мал, амьтны эзэн мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийг хэрэглэхийг зөвшөөрсөн гарын үсэг.

**Найм. Мал, амьтны эмийн жор бичихэд тавих шаардлага**

8.2.Эмийн ерөнхий нэршил (гол үйлчлэгч бодисын нэр) -ийг бичсэн байх;

8.3.Энэ журмын 6.1, 7.1-т заасан мэдээллийг бүрэн бичсэн байх;

8.4.Эмийн нэр, тун хэмжээг засварлаагүй байх;

**Ес. Энгийн эмийн жорыг бичих, баталгаажуулах**

9.1.Малын эмч энэ журмын 4.1-т зааснаас бусад тохиолдолд энгийн эмийн жорыг цахимаар үүсгэнэ.

9.2.Энэ журмын 4.1-т заасны дагуу цаасан жор үйлдсэн бол цахим системд хуанлийн 5 хоногийн дотор нөхөж оруулна.

9.3.Энэ журмын 9.2-т заасныг зөрчсөн тохиолдолд тухайн малын эмчид цахим системээс сануулга ирнэ. Цахим системээс 3-аас дээш удаа сануулга илгээгдсэн бол нэвтрэх эрх түр хаагдана.

9.4.Энэ журмын 9.3-т заасныг дагуу малын эмчийн цахим системд нэвтрэх эрх хаагдсан бол мал, амьтан эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн зхаиргааны байгууллагад хүсэлт гаргана.

9.5.Малын эмч энгийн эмийн жорыг үүсгэж дуусаад илгээмэгц цахим системээс дахин давтагдахгүй дугаар олгогдсоноор жор баталгаажна.

9.6.Энгийн эмийн жор цахим системд үүсгэгдсэн өдрөөс хойш хуанлийн 14 (арван дөрөв) хоногийн хугацаанд хүчинтэй байна.

9.7.Малын эмч өөрийн үүсгэсэн энгийн эмийн жорыг цаасан эсхүл цахим хэлбэрээр 2 жил хадгалах үүрэгтэй.

9.8.Нэг энгийн эмийн жорд 3-аас илүүгүй эм бичнэ. Хэрэв ижил төрлийн эмийг нэгээс олон мал, амьтанд өгч байгаа бол тэдгээрт нэг жор үйлдэж, мал, амьтны тоо /толгой/-г бичнэ.

**Арав. Тусгай эмийн жорыг бичих, баталгаажуулах**

10.1.Тусгай эмийн жорыг мал, амьтан тус бүрд үйлдэх ба нэг жорд нэг эм бичнэ.

10.2.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч тусгай эмийн жорыг цахим системд үүсгэхээс гадна маягт 2-ыг ашиглан цаасаар үйлдэж, энэ журмын 10.5-д заасан дахин давтагдахгүй дугаарыг цаасан жорын холбогдох хэсэгт бичнэ.

10.3.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тусгай цаасан жорын маягтыг серийн дугаартай нууцлалтай цаасан дээр хэвлэж, эрх бүхий мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид эсхүл хуулийн этгээдийн малын эмчид хүлээлгэж өгч бүртгэл хөтөлнө.

10.4.Энэ журмын 10.3-т заасан тусгай жорын бүртгэл хөтлөлтөд харьяалах сум, дүүргийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж дээд шатны төрийн захиргааны байгууллагад улирал

тутамд тайлагнана.

10.5.Тусгай эмийн жор нь цахим системээс дахин давтагдахгүй дугаар олгогдсоноор баталгаажна.

10.6.Тусгай эмийн жор нь системд үүсгэгдсэн өдрөөс хойш хуанлийн 5 /тав/ хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**Арваннэг. Эм худалдах**

11.1.Мал, амьтны эмийн сан цахим жороор олгох эмийг худалдахдаа  “Мал, амьтны эмийн санд тавих шаардлага” MNS 5545:2020  стандартыг баримтална.

11.2.Мал, амьтны эмийн сан нь цахим системд нэвтэрч, тухайн хүчинтэй жорд заасан эмийг энэ журмын 9.5 болон 10.5-д заасан давтагдахгүй дугаарыг ашиглан мал, амьтны эмийг олгоно.

11.3.Мал, амьтны эмийн сан нь цаасан жорыг үндэслэн мал, амьтны эмийг олгох ба энэ журмын 5.5 -д заасны дагуу бүртгэнэ.

11.4.Энгийн эмийн жорд заасан эмийг тухайн эмийн санд байгаа хэд хэдэн үйлдвэрийн эмээс мал, амьтны эзний сонголтоор олгох бөгөөд жорын дахин давтагдашгүй дугаар, олгосон эмийн нэр, тун, хэлбэр, тоо, хэмжээ, цувралын дугаар, импортлогчийн нэр, олгосон огноог цахим системд бүртгэнэ.

11.5.Тухайн эмийн санд жорд бичсэн нэг эсхүл хэд хэдэн эм байхгүй бол олгоогүй эмийг тухайн жорын давтагдахгүй дугаарыг ашиглан өөр эмийн сангаас авч болно.

11.6.Хэрэв шахмал эмийг ширхгээр, бусад хэлбэрийн эмийг жижиглэнгээр олгосон бол тусгайлан савлаж, эмийн нэр, хүчинтэй хугацаа, цувралын дугаар, хэрэглэх арга, хадгалах нөхцөл зэрэг мэдээллийг анхны савлагааны дээр байсантай ижил бичиж өгнө.

11.7.Жижиглэн савлах боломжгүй эмийг жорд заасан тун, хэмжээнд илүү тохирох хамгийн боломжит савлагаатай эмээс сонгон олгох ба илүү олгосон хэмжээг цахим системийн тайлбар хэсэгт оруулна.

11.8.Эмийн сан нь энэ журмын 11.6-д заасны дагуу илүү олгосон эмийг хэрхэн устгах талаар малчин, мал, амьтны эзэнд тайлбарлаж, бичиж өгнө.

11.9.Мал, амьтны эмийн сан өөрийн худалдсан жороор олгосон эмийн бүртгэлийг цаасан, эсхүл цахим байдлаар 2 жил хадгалах үүрэгтэй.

11.10.Энэ журмын 3.4-т заасан малын эмчтэй хуулийн этгээд нь тусгай эмийн жороор олгох эмийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8.2-т заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан эм ханган нийлүүлэх байгууллагаас гэрээний дагуу хүлээн авч зөвхөн өөрийн мал эмнэлгийн үйлчилгээнд хэрэглэх ба Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих

тухай хуульд заасны дагуу тайлагнах үүрэгтэй.

**Арванхоёр. Сургалт**

12.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цахим системд нэвтрэх, жор бичих талаарх сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулах, видео контент бэлтгэн хүргэх, цахим болон цаасан гарын авлага боловсруулж, түгээх үүргийг хүлээнэ.

**Арвангурав. Хяналт ба хариуцлага**

13.1.Энэ журмын хэрэгжилтэд бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад үр дүнг тайлагнана.

13.2.Энэ журамд заасан шаардлагыг зөрчсөнийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч тогтоосон бол Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 13.10 дугаар зүйлийн холбогдох заалтад заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хавсралт “Маягт № 1”

# Энгийн эмийн жорын маягт

**Энгийн эмийн жор**

............ оны ......... сарын ........ өдөр

Системээс олгогдсон дугаар: ..........................
Мал, амьтны эзний овог, нэр: ............................
Гэрийн хаяг: .......................................
Утасны дугаар: ......................
Мал, амьтны төрөл: ............................
Үүлдэр ..................... Зүс: ............................
Нас: .................. Хүйс: .................
Мал, амьтны бүртгэлийн дугаар /хэрэв байгаа бол/ ....................................................

Эм бичих хэсэг:

Малын эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг:
...................................... /...................................../
Малын эмчийн итгэмжлэлийн дугаар:
..................................................
Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, хуулийн этгээдийн нэр: ........................................................

| № | Эмийн ерөнхий нэр, хэлбэр, тун, давтамж | Хэрэглэх арга, хугацаа | Худалдсан /гарын үсэг/ |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |

Урд тал

Энгийн эмийн жорын маягтад 3-аас илүү эмийг бичихгүй ба энэхүү жор нь бичигдсэн өдрөөс хойш 14 хоногийн хугацаанд хүчинтэй.

Жорыг маягтын дагуу бүрэн бичээгүй, эмийн нэр, тун хэмжээг засварласан, малын эмчийн гарын үсэг, тэмдэггүй тохиолдолд хүчингүйд тооцно.

| Жор хүлээн авсан | Бэлтгэсэн | Шалгасан | Худалдсан | Огноо |
|---|---|---|---|---|
| | | | | |

Энэхүү хэсгийг эмийн сан энгийн жорын дагуу худалдсан эмийг тэмдэглэж, тасархай зураасын дагуу таслан эмийн хамт мал, амьтны эзэнд өгнө.

Хүнсний зориулалттай мал, амьтны биеэс эм гадагшлах хугацаа: .......................

**АНХААРУУЛГА:**
Мал, амьтны биеэс хэрэглэсэн эм гадагшлах хугацаа дуусаагүй байхад мал, амьтныг нядлахгүй ба мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн (сүү, өндөг г.м)-ийг авч ашиглахгүй.

Ард тал

Хавсралт “Маягт № 2”

# Тусгай эмийн жорын маягт

**Тусгай эмийн жор**

............. оны ......... сарын ........ өдөр

Системээс олгогдсон дугаар: ...........................
Мал, амьтны эзний овог, нэр: ............................
Гэрийн хаяг: .................................................
Утасны дугаар: ..................................
Мал, амьтны төрөл: ...........................
Үүлдэр ...................... Зүс: ...............................
Нас: .................. Хүйс: .................
Мал, амьтны бүртгэлийн дугаар /хэрэв байгаа бол/ .................................................
Эмийн зориулалт: ….................................

Эм бичих хэсэг:

Малын эмчийн нэр, гарын үсэг, тэмдэг:
................................ /......................................./
Малын эмчийн итгэмжлэлийн дугаар:
...................................................
Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, хуулийн этгээдийн нэр: ......................................................
Мал, амьтны эзний гарын үсэг:
........................................./................................/

| № | Эмийн ерөнхий нэр, хэлбэр, тун, давтамж | Хэрэглэх арга, хугацаа | Худалдсан /гарын үсэг/ |
|---|---|---|---|
| | | | |

Урд тал

Энгийн эмийн жорын маягтад 1-ээс илүү эмийг бичихгүй ба энэхүү жор нь бичигдсэн өдрөөс хойш 5 хоногийн хугацаанд хүчинтэй.

Жорыг маягтын дагуу бүрэн бичээгүй, эмийн нэр, тун хэмжээг засварласан, малын эмчийн гарын үсэг, тэмдэггүй тохиолдолд хүчингүйд тооцно.

| Жор хүлээн авсан | Бэлтгэсэн | Шалгасан | Худалдсан | Огноо |
|---|---|---|---|---|
| | | | | |

Энэхүү хэсгийг эмийн сан энгийн жорын дагуу худалдсан эмийг тэмдэглэж, тасархай зураасын дагуу таслан эмийн хамт мал, амьтны эзэнд өгнө.

Хүнсний зориулалттай мал, амьтны биеэс эм гадагшлах хугацаа: ........................

**АНХААРУУЛГА:**
Мал, амьтны биеэс хэрэглэсэн эм гадагшлах хугацаа дуусаагүй байхад мал, амьтныг нядлахгүй ба мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн (сүү, өндөг г.м)-ийг авч ашиглахгүй.

Ард тал

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртэлд
2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 7491 дүгээрт бүртгэв.*

## БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 07/04 | Хөхбүрд

## СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэг,ж, түүний удирдлагын тухай хуулийн  дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг албан байгууллага, ард иргэдэд танилцуулж, шинэчилсэн тарифаар хураамж тооцож ажиллахыг сумын Засаг дарга (Т.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр дагаж мөрдсүгэй.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 10/10, 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 02/02 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын нарийн бичгийн даргад даалгасугай.

ДАРГА Б.ЭРДЭНЭБААТАР

Бүртгэлийн дугаар 156
БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбарыг олгосон албан тушаалтны гарын үсэг
25 он 12 сар 25 өдөр

6425010026

[illegible]

*иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
7 дугаар хуралдааны 07/04 дүгээр
тогтоолын хавсралт*

## ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

<table>
<tr><th>№</th><th colspan="2">Үйлчилгээний төрлүүд</th><th>Хэмжих нэгж</th><th>Хураамж /төгрөг/</th></tr>
<tr><td>1</td><td colspan="2">Төрийн болон төрийн бус байгууллагын энгийн хог хаягдал</td><td>Сар бүр</td><td>50,000</td></tr>
<tr><td>2</td><td colspan="2">Уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж</td><td>Сар бүр</td><td>50,000</td></tr>
<tr><td>3</td><td colspan="2">Авто угаалга, дугуй засвар</td><td>Сар бүр</td><td>20,000</td></tr>
<tr><td>4</td><td colspan="2">Худалдаа үйлчилгээний газар, дэлгүүр, гуанз, бар, ресторан, хоол үйлдвэрлэлийн газар</td><td>Сар бүр</td><td>50,000</td></tr>
<tr><td>5</td><td colspan="2">Ил задгай талбайд худалдааны үйл ажиллагаа эрхлэгч дэлгүүр, баяр наадмын үеэр барьсан цайны газар, бусад цэгүүд</td><td>Сар бүр</td><td>50,000</td></tr>
<tr><td>6</td><td colspan="2">Хөрөө рам, модон эдлэлийн үйлдвэр, ноос эсгийн үйлдвэр</td><td>Сар бүр</td><td>20,000</td></tr>
<tr><td>7</td><td colspan="2">Амралт, сувилалын байгууллагын хог хаягдал</td><td>Сар бүр</td><td>50,000</td></tr>
<tr><td>8</td><td colspan="2">Шатахуун түгээх газар</td><td>Сар бүр</td><td>20,000</td></tr>
<tr><td>9</td><td colspan="2">Сумын төвийн өрх /Нэг иргэний тооцооллоор/</td><td>Сар бүр</td><td>10,000</td></tr>
<tr><td rowspan="3">10</td><td rowspan="3">Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААНБ</td><td>Ашиглалт</td><td>Сар бүр</td><td>200,000</td></tr>
<tr><td>Хайгуул</td><td>Сар бүр</td><td>100,000</td></tr>
<tr><td>Бичил уурхай</td><td>Сар бүр</td><td>50,000</td></tr>
</table>

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 7492 дугаарт бүртгэв.*

# ДОРНОГОВЬ АЙМАГ УЛААНБАДРАХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 22 | Улаанбадрах сум

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйл, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Суманд нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээг тэмээ-400, адуу-400, үхэр-400, хонь-300, ямаа-400 төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2.Малын тоо толгойн албан татварыг тогтоосон хэмжээгээр хураах, жил бүрийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Эрхэмболд)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг Хууль зүйн яаманд бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд хэвлэгдсэнээр дагаж мөрдсүгэй.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 20/33 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.МӨНХ-ЭРДЭНЭ

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 7493 дугаарт бүртгэв.*

# СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр　　Дугаар 5/51　　Ширээт

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1,48.2, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит 5 дугаар хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1.2022 - 2024 онуудад байгаль цаг агаарын хүндрэлтэй байсны улмаас мал сүрэг олноор хорогдож, малчдын амжиргаа ихээр буурсан тул малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг 2026 онд /0/ тэг төгрөг байхаар тогтоосугай.

2.Татвартай холбоотой ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг сумын засаг дарга /Д.Аваажигмэд/, татварын улсын байцаагч /Б.Батгэрэл/ нарт даалгасугай.

3.Энэхүү тогтоол хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн 2025 оны 03 дугаар сарын 12 ны өдрийн 4/33 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын санхүү эдийн засгийн хяналтын хороонд даалгасугай.

ДАРГА　　Я.ЭРДЭНЭБАТ

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 7494 дугаарт бүртгэв.*

# СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Дугаар 47 Хавирга

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит наймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Малчин, мал бүхий иргэдийн малын тоо толгойд ногдох албан татварын хэмжээг нэгдүгээр хавсралтаар, амьжиргаа дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойд ногдох албан татварын хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Албан татварыг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэн зориулалтын үйл ажиллагаанд зарцуулан ажиллахыг сумын Засаг дарга /Д.Энхбаатар/, татварын орлогын төлөлт, төвлөрүүлэлтийг хангаж ажиллахыг Санхүү албаны дарга (Х.Наранжаргал), татвар хураагч (Т.Баяржаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин биелэлтийг тооцож ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх байгаль орчин, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн хороонд даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 02 дугээр сарын 25-ний өдрийн 33 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Г.ЭРДЭНЭБААТАР

[illegible]

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын*
*ээлжит наймдугаар хуралдааны 2025*
*оны 12 сарын 19-ний өдрийн 47 дугаар*
*тогтоолын нэгдүгээр хавсралт*

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

| Дэс дугаар | Малын төрөл | Ногдох албан татвар |
|---|---|---|
| 1 | Адуу | 500 |
| 2 | Үхэр | 400 |
| 3 | Тэмээ | 0 |
| 4 | Хонь | 600 |
| 5 | Ямаа | 600 |

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит наймдугаар хуралдааны 2025
оны 12 сарын 19-ний өдрийн 47 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт*

## АМЬЖИРГАА ДЭМЖИХ ЗОРИЛГООР МАЛЧНЫ ӨМЧИЛЖ БАЙГАА МАЛЫН ТОО ТОЛГОЙНД НОГДОХ АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

| Дэс дугаар | Малын төрөл | Албан татвараас чөлөөлөгдөх малын тоо | Ногдох албан татвар |
|---|---|---|---|
| 1 | Адуу | 10 | 0 |
| 2 | Үхэр | 10 | 0 |
| 3 | Тэмээ | 0 | 0 |
| 4 | Хонь | 70 | 0 |
| 5 | Ямаа | 60 | 0 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд*
*2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 7495 дугаарт бүртгэв.*

# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Дугаар 15 Дархан

## ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн 9.2.1, 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифийг нэгдүгээр хавсралтаар, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2.Уг тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Б.Болдбаатар)-д даалгасугай.

3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хэрэгжүүлж, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, зориулалтын дагуу зарцуулж, хэрэгжилтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга (Т.Тулгаа), Дархан хотын Хог тээвэр ОНӨААТҮГ-ын дарга (Л.Отгонбаяр) нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.ЭРДЭНЭЗАЯА

*Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 15 дугаар
тогтоолын нэгдүгээр хавсралт*

## ДАРХАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ МӨРДӨХ ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

| № | Үйл ажиллагааны төрөл | Хэмжих нэгж | Үнийн тариф (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Энгийн хог хаягдлыг тээвэрлэх зардал | тонн | 50,000 |

*Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 15 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт*

## ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

<table>
<tr><th>№</th><th colspan="2">Нэгжийн нэр</th><th>Өдөрт үүсгэх хог хаягдлын хэмжээ</th><th>Хэмжих нэгж</th><th>Хураамжийн хэмжээ (төгрөгөөр)</th></tr>
<tr><td>1</td><td colspan="2">2</td><td>3</td><td>4</td><td>5</td></tr>
<tr><td rowspan="2">1</td><td rowspan="2">Нэг өрхийн, ахуйн хог хаягдлын үйлчилгээний хураамж</td><td>Гэр хорооллын айл өрх</td><td rowspan="2"></td><td rowspan="2">Сар бүр</td><td>10,000</td></tr>
<tr><td>Нийтийн зориулалттай орон сууц болон амины орон сууцтай айл өрх</td><td>15,000</td></tr>
<tr><td>2</td><td colspan="2" rowspan="3">Өрхийн хашаандаа болон орон сууцны 1-р давхар, зоорийн давхарт үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуй нэгжүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамж</td><td>Бага (0.04 тонн)</td><td>Сар бүр</td><td>20,000</td></tr>
<tr><td>3</td><td>Дунд (0.1 тн)</td><td>Сар бүр</td><td>35,000</td></tr>
<tr><td>4</td><td>Их (0.5 тонн)</td><td>Сар бүр</td><td>60,000</td></tr>
<tr><td>5</td><td colspan="2" rowspan="3">Орон сууцны хорооллын дунд тусгай объектод байрлаж үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамж</td><td>Бага (0.04 тонн)</td><td>Сар бүр</td><td>20,000</td></tr>
<tr><td>6</td><td>Дунд (0.1 тонн)</td><td>Сар бүр</td><td>40,000</td></tr>
<tr><td>7</td><td>Их (0.5 тонн)</td><td>Сар бүр</td><td>60,000</td></tr>
</table>

Тайлбар: Хог хаягдлын тухай хуулийн 41.6-д заасны дагуу айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцоход 4,416.50 төгрөг байна. Дархан сумын айл өрхийн дундаж ам бүлийн тоог 3.37 гэж үзвэл нэг айл өрхөд ноогдох сарын хураамж 15,016.1 төгрөг болж байна. Иймд гэр хороолол болон инженерийн дэд бүтэцтэй орон сууцны айл өрхийн өдрт үүсгэх хог хаягдлын хэмжээ, хог татан авалтын маршрут түүнийг дагалдаж гарах зардлын хэмжээг харгалзан уг дүнгээс хэтрүүлэхгүйгээр /гэр хороолол, байшин хороолол/ ялгамжтайгаар тогтоов.

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 7496 дугаарт бүртгэв.*

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ СҮМБЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 06 | Сүмбэр сум |

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 52 дугаар зүйлийн 52.1.2, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.15, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлйин 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Малын төрөл тус бүрээр тогтоосон малын тоо толгойн татварыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Ц.Алтанцэцэг/-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангаж, бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Э.Даваадоржид/-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбоотой иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Т.ТҮМЭНБАЯР

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн*
*Хурлын ээлжит 09 дүгээр хуралдааны*
*2025 оны 12 дугаар сарын 18-ны*
*өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт*

# МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ МАЛЫН ТӨРӨЛ ТУС БҮРЭЭР ТОГТООСОН ЖАГСААЛТ

| № | Малын төрөл | 1 толгой малд ногдох татварын хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Тэмээ | 0 | |
| 2 | Адуу | 1000 | |
| 3 | Үхэр | 800 | |
| 4 | Хонь | 500 | |
| 5 | Ямаа | 1000 | |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 7497 дугаарт бүртгэв.*

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 9/07 | Зүүнбаян-Улаан сум

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сумын малчин, мал бүхий иргэдийн өмчилж байгаа малын төрөл тус бүрээр тоо толгойд ногдуулсан албан татварын хэмжээг шинэчлэн баталж хавсралтаар баталсугай.

2.Тухайн жилд ногдуулсан албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажиллахыг Засаг дарга (Х.Балжинням), багийн засаг дарга нар, татварын улсын байцаагчид, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд  мэдээлж ажиллахыг ажлын хороодод тус тус үүрэг болгосугай.

3.Тогтоолтой холбогдох баримт бичгийг бүрдүүлж хуульд заасан хугацаанд Хууль Зүй, Дотоод Хэргийн яаманд хянуулахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Одонжаргал)-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулж 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 16/01 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА Т.ХҮРЭЛБААТАР

*Сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 18-ны
өдрийн 9/07 дугаар тогтоолын хавсралт*

# МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ШИНЭЧИЛСЭН ХЭМЖЭЭ

| № | Малын төрөл | Нэг толгой малд ноогдох татварын хэмжээ |
|---|---|---|
| | | Малчин, мал бүхий өрх |
| 1. | Тэмээ | |
| 2. | Адуу | 1000 |
| 3. | Үхэр | 1000 |
| 4. | Хонь | 800 |
| 5. | Ямаа | 800 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд*
*2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7498 дугаарт бүртгэв.*

# ӨМНӨГОВЬ АЙМАГ БАЯНДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 6/03 | Баяндалай сум |

## МАЛЫН ХӨЛИЙН АЛБАН ТАТВАР ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 351.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Малын тоо толгойд ногдох албан татварыг хавсралтаар баталсугай.

2.Уг тогтоолыг зохих хууль журмын дагуу холбогдох газарт бүртгүүлж, үйлчилгээний хураамжийг дагаж мөрдүүлэн, төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлж ажиллахыг сумын Засаг дарга (У.Буян-Өлзий ), Татварын Улсын байцаагч (С.Баттогтох) нарт даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 14/03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА Б.НАРМАНДАХ

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн
6/03 дугаар тогтоолын хавсралт*

# МАЛЫН ХӨЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

| Малын нэр төрөл | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|
| Нэг малд ногдох албан татварын хэмжээ (төг) | 50 | 50 | 50 | 50 | 50 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7499 дүгээрт бүртгэв.*

## ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 06 | Хайрхан

## МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Сумын Засаг дарга С.Өлзийсүрэнгийн өргөн мэдүүлсэн малын тоо толгойн албан татварын хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын төсөл холбогдох мэдээллийг хэлэлцээд Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 22 дугаар зүйлийн 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 49 дугаар зүйлийн 49.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит зургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын малчин болон мал бүхий өрхийн малын тоо толгой тутамд ногдуулах малын тоо толгойн албан татварын хэмжээг тэмээ 0, адуу 350, үхэр 200, хонь 300, ямаа 400, төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

2.Ган, зуд, гамшгийн улмаас мал хорогдсон бол Сумын онцгой комиссын шийдвэрийг үндэслэн нийтмалын тооноос хасаж тооцож, татвараас чөлөөлсүгэй.

3.Малын тоо толгойд ногдуулсан албан татварыг жил бүрийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор төлж, сумын төсөвт төвлөрүүлэхийг малчин, Мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, малчин, мал бүхий иргэдэд сурталчилж, холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга (С.Өлзийсүрэн)-д үүрэг болгосугай.

5.Энэхүү тогтоолыг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэн Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн санд бүртгүүлж, мөрдүүлэх арга хэмжээ авахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (М.Батхүү)-д даалгасугай.

6.Энэхүү тогтоол шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн “Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай” тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА Л.ЖАНЦАННОРОВ

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд*
*2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7500 дугаарт бүртгэв.*

# ХОВД АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 06 | Ховд

## “БҮРЭН СТАНДАРТ” ХХК-ИЙН ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Ховд сумын төвийг дулаанаар хангагч “Бүрэн стандарт” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Ховд сумын төвийг дулаанаар хანган ажиллаж буй “Бүрэн стандарт” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд”-д нийтэлсний дараа мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 06 дугаар сарын 12 өдрийн 14 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

ДАРГА Б.ГОМБОСҮРЭН

ГИШҮҮН Б.АНХБАЯР
ГИШҮҮН З.БАТЗАЯА

*Зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 тоот тогтоолын хавсралт*

## ДУЛААНЫ “БҮРЭН СТАНДАРТ” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

Ховд аймгийн “Бүрэн стандарт” ХХК-ийн эзэмшлийн Ховд сумын дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /нөат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

<table>
<tr><th>№</th><th>Хэрэглэгчдийн ангилал</th><th>Хэмжих нэгж</th><th>Тариф<br>/ нөат-гүй/</th></tr>
<tr><td>1</td><td>Төсөвт байгууллагуудын халаалт</td><td>Төг/м3</td><td>2850.0</td></tr>
<tr><td>2</td><td>Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын халаалт</td><td>Төг/м3</td><td>1650.0</td></tr>
<tr><td>3</td><td>Айл өрхийн халаалт</td><td>Төг/хүн</td><td>1200.0</td></tr>
<tr><td>4</td><td rowspan="2">Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан</td><td>Төг/м3</td><td>2000.0</td></tr>
<tr><td>5</td><td>Төг/хүн</td><td>6000.0</td></tr>
</table>

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7501 дүгээрт бүртгэв.*

# ХОВД АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 07 | Ховд

## “БҮРЭН СТАНДАРТ” ХХК-ИЙН ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Эрдэнэбүрэн сумын төвийг дулаанаар хангагч “Бүрэн стандарт” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын төвийг дулаанаар ханган ажиллаж буй “Бүрэн стандарт” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд”-д нийтэлсний дараа мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 06 дугаар сарын 12 өдрийн 13 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

ДАРГА Б.ГОМБОСҮРЭН

ГИШҮҮН Б.АНХБАЯР
ГИШҮҮН З.БАТЗАЯА

*Зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 07 тоот тогтоолын хавсралт*

## “БҮРЭН СТАНДАРТ” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

Ховд аймгийн “Бүрэн стандарт” ХХК-ийн эзэмшлийн Эрдэнэбүрэн сумын дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /нөат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

| № | Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф /нөат-гүй/ |
|---|---|---|---|
| 1 | Төсөвт байгууллагуудын халаалт | Төг/м3 | 2850.0 |
| 2 | Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын халаалт | Төг/м3 | 1650.0 |
| 3 | Айл өрхийн халаалт | Төг/хүн | 1200.0 |
| 4 | Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан | Төг/м3 | 2000.0 |
| 5 | | Төг/хүн | 6000.0 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7502 дугаарт бүртгэв.*

# ХОВД АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 08 | Ховд |

## “ТООСГОН УУЛ” ХХК-ИЙН ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Алтай сумын төвийг дулаанаар хангагч “Тоосгон уул” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Алтай сумын төвийг дулаанаар ханган ажиллаж буй “Тоосгон уул” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд”-д нийтэлсний дараа мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 06 дугаар сарын 12 өдрийн 10 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

| | |
|---|---|
| ДАРГА | Б.ГОМБОСҮРЭН |
| ГИШҮҮН | Б.АНХБАЯР |
| ГИШҮҮН | З.БАТЗАЯА |

*Зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын
19-ний өдрийн 08 тоот тогтоолын хавсралт*

# ДУЛААНЫ “ТООСГОН УУЛ” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

“Тоосгон уул” ХХК-ийн эзэмшлийн Алтай сумын дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /нөат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

| № | Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф / нөат-гүй/ |
|---|---|---|---|
| 1 | Төсөвт байгууллагуудын халаалт | Төг/м3 | 2640.0 |
| 2 | Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын халаалт | Төг/м3 | 1940.0 |
| 3 | Айл өрхийн халаалт | Төг/хүн | 1620.0 |
| 4 | Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан | Төг/м3 | 2000.0 |
| 5 | | Төг/хүн | 6000.0 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7503 дугаарт бүртгэв.*

# ХОВД АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр    Дугаар 09    Ховд

## “ТООСГОН УУЛ” ХХК-ИЙН ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Мянгад сумын төвийг дулаанаар хангагч “Тоосгон уул” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Мянгад сумын төвийг дулаанаар ханган ажиллаж буй “Тоосгон уул” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд”-д нийтэлсний дараа мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 06 дугаар сарын 12 өдрийн 09 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

ДАРГА    Б.ГОМБОСҮРЭН

ГИШҮҮН    Б.АНХБАЯР
ГИШҮҮН    З.БАТЗАЯА

*Зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 09 тоот тогтоолын хавсралт*

# ДУЛААНЫ “ТООСГОН УУЛ” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

“Тоосгон уул” ХХК-ийн эзэмшлийн Мянгад сумын дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /нөат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

| | Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф /нөат-гүй/ |
|---|---|---|---|
| 1 | Төсөвт байгууллагуудын халаалт | Төг/м3 | 2600.0 |
| 2 | Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын халаалт | Төг/м3 | 1900.0 |
| 3 | Айл өрхийн халаалт | Төг/хүн | 1620.0 |
| 4 | Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан | Төг/м3 | 2000.0 |
| 5 | | Төг/хүн | 6000.0 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7504 дугаарт бүртгэв.*

# ХОВД АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 10 | Ховд |

## “ЭРДЭС ТАЙГА” ХХК-ИЙН ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Чандмань сумын төвийг дулаанаар хангагч “Эрдэс тайга” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Чандмань сумын төвийг дулаанаар хангаж ажиллаж буй “Эрдэс тайга” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд”-д нийтэлсний дараа мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 06 дугаар сарын 12 өдрийн 16 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

| | |
|---|---|
| ДАРГА | Б.ГОМБОСҮРЭН |
| ГИШҮҮН | Б.АНХБАЯР |
| ГИШҮҮН | З.БАТЗАЯА |

*Зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 10 тоот тогтоолын хавсралт*

## ДУЛААНЫ “ЭРДЭС ТАЙГА” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

“Эрдэс тайга” ХХК-ийн эзэмшлийн Чандмань сумын дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /нөат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

| № | Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф /нөат-гүй/ |
|---|---|---|---|
| 1 | Төсөвт байгууллагуудын халаалт | Төг/м3 | 2640.0 |
| 2 | Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын халаалт | Төг/м3 | 1940.0 |
| 3 | Айл өрхийн халаалт | Төг/хүн | 1620.0 |
| 4 | Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан | Төг/м3 | 2000.0 |
| 5 | | Төг/хүн | 6000.0 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7505 дугаарт бүртгэв.*

# ХОВД АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 11 | Ховд

## “ЭРДЭС ТАЙГА” ХХК-ИЙН ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Дуут сумын төвийг дулаанаар хангагч “Эрдэс тайга” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Дуут сумын төвийг дулаанаар ханган ажиллаж буй “Эрдэс тайга” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд”-д нийтэлсний дараа мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 06 дугаар сарын 12 өдрийн 15 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

ДАРГА Б.ГОМБОСҮРЭН

ГИШҮҮН Б.АНХБАЯР
ГИШҮҮН З.БАТЗАЯА

*Зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 11 тоот тогтоолын хавсралт*

## ДУЛААНЫ “ЭРДЭС ТАЙГА” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

“Эрдэс тайга” ХХК-ийн эзэмшлийн Дуут сумын дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /нөат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

| № | Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф /нөат-гүй/ |
|---|---|---|---|
| 1 | Төсөвт байгууллагуудын халаалт | Төг/м3 | 2800.0 |
| 2 | Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын халаалт | Төг/м3 | 1940.0 |
| 3 | Айл өрхийн халаалт | Төг/хүн | 1620.0 |
| 4 | Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан | Төг/м3 | 2000.0 |
| 5 | | Төг/хүн | 6000.0 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7506 дугаарт бүртгэв.*

# ХОВД АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр — Дугаар 12 — Ховд

## “ЭРЧИМ ДӨЛ” ХХК-ИЙН ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Цэцэг сумын төвийг дулаанаар хангагч “Эрчим дөл” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Цэцэг сумын төвийг дулаанаар хангаан ажиллаж буй “Эрчим дөл” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд”-д нийтэлсний дараа мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 06 дугаар сарын 12 өдрийн 12 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

ДАРГА Б.ГОМБОСҮРЭН

ГИШҮҮН Б.АНХБАЯР

ГИШҮҮН З.БАТЗАЯА

*Зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 12 тоот тогтоолын хавсралт*

# ДУЛААНЫ “ЭРЧИМ ДӨЛ» ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

“Эрчим дөл” ХХК-ийн эзэмшлийн Цэцэг сумын дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /нөат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

| № | Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф / нөат-гүй/ |
|---|---|---|---|
| 1 | Төсөвт байгууллагуудын халаалт | Төг/м3 | 2850.0 |
| 2 | Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын халаалт | Төг/м3 | 1650.0 |
| 3 | Айл өрхийн халаалт | Төг/хүн | 1200.0 |
| 4 | Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан | Төг/м3 | 2000.0 |
| 5 | | Төг/хүн | 6000.0 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд*
*2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 7507 дугаарт бүртгэв.*

# ХОВД АЙМГИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 13 | Ховд |

## “ЭРЧИМ ДӨЛ” ХХК-ИЙН ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Манхан сумын төвийг дулаанаар хангагч “Эрчим дөл” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Манхан сумын төвийг дулаанаар ханган ажиллаж буй “Эрчим дөл” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд”-д нийтэлсний дараа мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 06 дугаар сарын 12 өдрийн 11 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

| | |
|---|---|
| ДАРГА | Б.ГОМБОСҮРЭН |
| ГИШҮҮН | Б.АНХБАЯР |
| ГИШҮҮН | З.БАТЗАЯА |

*Зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 13 тоот тогтоолын хавсралт*

# ДУЛААНЫ “ЭРЧИМ ДӨЛ” ХХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

“Эрчим дөл” ХХК-ийн эзэмшлийн Манхан сумын дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /нөат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

| № | Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф /нөат-гүй/ |
|---|---|---|---|
| 1 | Төсөвт байгууллагуудын халаалт | Төг/м3 | 2850.0 |
| 2 | Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын халаалт | Төг/м3 | 1650.0 |
| 3 | Айл өрхийн халаалт | Төг/хүн | 1200.0 |
| 4 | Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан | Төг/м3 | 2000.0 |
| 5 | | Төг/хүн | 6000.0 |

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд*
*2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авсан.*

## ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 250 | Улаанбаатар хот |

## “ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-Д ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл шаардлагыг Зохицуулах хорооноос олгосон телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд дагаж мөрдөнө.” гэж, 1.8 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.” гэж, 3 дугаар зүйлийн 3.25 дахь хэсгийг “Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай, хөтөлбөрийн онцлогт тохирсон хүний нөөцийг бүрдүүлсэн, мэргэжлийн инженер техникийн ажилтантай байна.” гэж, 3.27 дахь хэсгийг “Үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөл шинээр авч, үйл ажиллагаа эхлүүлэхийн өмнө техникийн үйл ажиллагааг шалгаж жигдрүүлэх туршилтыг хоёр сараас илүүгүй хугацаанд хийнэ.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл шаардлагын 4.1-д заасан журам, хэмжилт, шалгалтын дүнг Зохицуулах хорооноос шаардсан тохиолдолд тухай бүр ирүүлнэ.” гэж, 4.9 дэх хэсгийг “Дууны түвшинг хянах, тохируулах чиг үүргийг холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусган үүрэгжүүлсэн байна.” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

2.“Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3, 3.15, 3.26 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 хэсэг, 6.5.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД Б.АНХБААТАР
Б.БАТЗОРИГ
Ч.ЗОЛБАЯР
А.ЛУВСАН-ОЧИР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авсан.*

# ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 251 | Улаанбаатар хот |

## “РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ГАЗРЫН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-Д ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.6 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.” гэж, 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийг “Үйлчилгээ эрхлэгч радио, телевизийн хөтөлбөрийн хуваарь, мэдээллийг үзэгч, сонсогчид хүргэх (EPG) системтэй байна.” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

2.“Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 1.5 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД Б.АНХБААТАР
Б.БАТЗОРИГ
Ч.ЗОЛБАЯР
А.ЛУВСАН-ОЧИР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авсан.*

## ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 252 | Улаанбаатар хот |

## “ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”- Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 6 дугаар зүйлд “6.21 Үйлчилгээ эрхлэгч нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8-д заасныг баримтлан хязгаарлалт хийх ба 18+ насны ангиллын кино, контентийг өөрийн үйлчилгээний промо сувгаар сурталчилахгүй.” гэж, 6.15 дахь хэсгийн “Үйлчилгээ эрхлэгч нь” гэсний дараа “Мэдээлэл харилцаа холбооны техникийн өрөөнд тавих шаардлага MNS 6869” гэж, 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсгийн “үйлчилгээ эрхлэгч нь” гэсний өмнө “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх хүрээтэй” гэж тус тус нэмсүгэй.

2.“Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.” гэж, 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг “Олон суваг дамжуулах үйлчилгээг нийтийн интернэт (ОТТ технологи)-ээр дамжуулан хүргэхэд үйлчилгээ эрхлэх хүрээг тодорхой бүс нутгаар хязгаарлахгүй.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг “Үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээний чанар, тасралтгүй найдвартай ажиллагааг хянах, дамжуулж буй радио, телевизийн дохионы чанар, дуу, дүрсийн үзүүлэлтийг холбогдох стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг тогтмол хянах, хэмжих, тохируулах дотоод журмыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.12 дахь хэсгийг “Утасгүй болон хиймэл дагуулын сүлжээгээр олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь хамрах хүрээний шаардлагыг хангаж байгаа болохыг хэрэглэгчийн өргөдөл, гомдолд үндэслэн хэмжилт

хийдэг, шаардлагатай үед Зохицуулах хороонд ирүүлдэг байна.” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг “Үйлчилгээ эрхлэгч нь тухайн улсынхаа хуулийн дагуу зөвшөөрөлтэй гадаадын радио, телевизийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан гэрээ байгуулан дамжуулна.” гэж, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “регистрийн дугаарыг” гэснийг “иргэний бүртгэлийн дугаараар” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

3.“Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 1.6 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.13 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1, 5.8, 5.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД Б.АНХБААТАР
Б.БАТЗОРИГ
Ч.ЗОЛБАЯР
А.ЛУВСАН-ОЧИР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хүлээн авсан.*

## ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр | Дугаар А/316 | Улаанбаатар хот

## ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зуйлийн 60.1.2, 60.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Төмөр замын тээврийн тухай хууль (шинэчилсэн найруулга) 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж буйтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны “Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм батлах тухай” А/154 дүгээр тушаалын долдугаар хавсралтаар баталсан “Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам”, арван хоёрдугаар хавсралтаар баталсан “Төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам”, арван зургаадугаар хавсралтаар баталсан “Суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам ашиглах, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах болон тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээний үлгэрчилсэн загвар”, мөн Зам, тээврийн хөгжпийн сайдын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 146, 148 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хүлээн авсан.*

## ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

| | | |
|---|---|---|
| 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар А/326 | Улаанбаатар хот |

## ТУШААЛЫН ХАВСРАЛТ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зуйлийн 60.1.2, 60.1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Төмөр замын тээврийн тухай хууль (шинэчилсэн найруулга) 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж буйтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын (хуучин нэрээр) 2020 оны “Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм батлах тухай” А/154 дүгээр тушаалын арван дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл”, мөн тушаалын арван долоодугаар хавсралтаар баталсан “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Б.ДЭЛГЭРСАЙХАН